

ДАРХАН ХОТЫГ ДЭЛХИЙТЭЙ ХОЛБОСОН "НАЙРАМДАЛ" ТӨСӨЛ



Co-funded by
the European Union



ДАРХАН-УУЛ АЙМАГЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



Network of Associations of
Local Authorities of South-East Europe



FRIENDSHIP
FOR INNOVATION
PROSPERITY
AND GREENING

Агуулга



Эрхлэгчийн зурвас 03
Дархан хот бусад аймагт
туршлага, мэдлэгээ
хуваалцаасай


Онцлох нийтлэл 04
“Найрамдал” төсөл Дархан
хотыг Европтой ойртуулав

Тоон мэдээлэл 06

Онцлох ярилцлага 08
П.Мэнд-Амгалан:
Дархан дэлхийн хот болсон

“Найрамдал”-ын үр шим 14
Дархан 14 улсын
9000 хоттой нэгдэв

Зөвлөх 16
Камлеш Кумар Патак:



Дархан хот Европын
Комиссын “Дэлхийн Гарц”
санаачилгатай хамтран
ажиллах гүүр болно
нэмэгдүүлсэн он жилүүд

Хамтын ажиллагаа 18
Дархан-Уул аймаг гадаад
хамтын ажиллагаагаараа
орон нутагт манлайлж
байна

Албаны хүний үг 22
О.Хүрэлчулуун:
“Найрамдал” шиг төсөл
Монголд байхгүй

Нөөц боломжийг нээх нь 24
Дархан-Европын бүс
нутгийн форум байгуулагдав

Төрийн албан хаагч 26
“Онц сурлагатан”



**Иргэдийн оролцоот
засаглал 28**
Маргаашийн хот

Шигтгээ үг 32

Инновац 34
Европ-Дарханы Инновац
Энтерпренершип төв
шилдэг 10 гарааны
бизнесийг бойжуулж байна

Шигтгээ үг 38

Хөрсөн бортого 40
“Хөрсөн бортого”
үйлдвэрлэгч

Зөгийн бал 41
Х.Золзаяа: “Найрамдал”
төсөл бизнес эрхлэгчдийн
харах өнцгийг өөрчилсөн



Мөөг 43
Б.Алимантуяа: Яг
шантраад урам хугарах
үед “Найрамдал” төсөлтэй
холбогдсон

Утаагүй зуух 44
Э.Баатар: “Ихэр дөл” зуух
нүүрсээ өөрөө коксжуулж,
утаа бага ялгаруулдаг

“Science” кафе 46
Кофе уунгаа шинжлэх
ухааны туршилт хийгээрэй

**“Өөрчлөлтийг хамтдаа
авчиръя” 47**
700 гаруй сая төгрөгийн
6 зорилтот төсөл
хэрэгжүүлэв

Эрхлэгчийн зурвас

Дархан хот бусад аймагтай туршлага, мэдлэгээ хуваалцаасай



Д.БЭХБАЯР
Mongolian Economy
сэтгүүлийн эрхлэгч

Европын Холбооны нэгэн гайхалтай төсөл Дархан хотод хэрэгжээд дуусаж байна. Гайхалтай гэж тодотгосны учир нь Азийн хотод хэрэгжиж буй анхны тохиолдол. Эрдэмтэн докторуудын санаачилга, идэвх зүтгэлээр Европын холбооноос төсөл авч чадсан онцлогтой. Хүмүүсийн ухамсар сэтгэхүйтэй ажиллахыг чухалчилсан, мэдлэг мэдээлэл өгөхөд чиглэсэн төсөл. Онол практикийг хослуулж, Европын олон хотуудын хөгжил цэцэглэлт, хүн ардын соёл, өвтэй биеэр танилцуулсан төсөл. Форум гэдэг ойлголтыг халж, шинэ шатанд гаргахад үлгэрлэсэн төсөл. Олон улсын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, Их дээд сургууль, эрдэмтэн доктор, хувийн хэвшлийнхний хамтын нэгдэл, зүтгэлийг харуулсан төсөл.

Энэ бол Дархан хотноо гурван жил хэрэгжээд дуусаж буй Европын Холбооны хамтарсан 3 сая еврогийн санхүүжилттэй “Найрамдал” төсөл юм.

Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Агроэкологи бизнесийн сургуулийн эрдэмтэн багш П.Мэнд-Амгалан төслийн санааг анхлан гаргаж, өөрөө гардан боловсруулж, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар дэмжсэнээр аймагтаа энэхүү төслийг авчирсан билээ. Африкийн улс орнууд руу зорилгоо чиглүүлдэг төслийг Монголдоо, тэр дундаа Дархан хотдоо хэрэгжүүлэхийн төлөө дэлхийн олон улстай өрсөлдөн Ази тивдээ анхны тодотголтойгоор уг төслийг авчирч чадсан нь бахархалтай. Төсөв хэрэгжсэн хугацаанд олон олон үр дүн, өвөрмөц

үйл явдлууд өрнөснийг энэхүү дугаартаа цогцоор хүргэж байна.

Хамгийн гол хэлэх зүйл бол бусад аймаг энэхүү санааг үлгэрлэн авч, сэтгэл оюунаа гаргаад ажиллавал ийм зорилготой гоё төслүүдийг хэрэгжүүлэх боломж дэлхийд байна гэдгийг харуулахыг хүсэв. Мөн Дархан уул аймаг, Дархан хот бусад аймагт туршлага, мэдлэгээ хуваалцаасай. Учир нь Дархан уг төслийн үр шимээр Европын гурван хоттой хамтран ажиллахаар болж, олон хоттой холбогдож, хөгжлөөс нь газар дээр нь аялж, харж, туршлага хуваалцсан. “Дархан дэлхийн хот болсон. Цаашид бусад аймагтайгаа хамтарч, холбоо байгуулан хөгжих боломж бий” гэж төслийг санаачлагч “Найрамдал” төслийн удирдагч, Европ-Дарханы Инновац, Энтрепренершип төвийн захирал, доктор П.Мэнд-Амгалан онцолж байна. Тэрбээр төслийн нэрээ Найрамдлын Дархан хотыг эргэн сэргээж, дэлхийн хотын нэг болгох итгэл үнэмшлээр “Найрамдал” гэж төслөө нэрлэсэн билээ. Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга О.Хүрэлчулуун “Найрамдал шиг төсөл Монголд байхгүй” гэсэн юм.

Найрамдлын Дархан буцан сэргэж ирсэн гэдгийг энэхүү төсөл бүрэн утгаар нь харуулна. Төр, шинжлэн ухаан, эрдэмтэн докторууд хамтран ажиллавал ямар том зүйлийг бий болгож, үр дүнд хүргэдгийг “Найрамдал” төслөөс бэлхнээ харж болно. Ийм төсөл 21 аймагт хэрэгжээсэй. Үүний төлөө орон нутгийн удирдлагууд санаачилгатай ажиллаасай гэж хүснэм. ■

Онцлох нийтлэл

“Найрамдал” төсөл Дархан хотыг Европтой ойртуулав



Монгол Улсын хоёр дахь нийслэл хэмээгддэг Дархан хот өдгөө ид хөгжин цэцэглэж байна. Хүмүүсийн хүсдэг цэвэрхэн, амар амгалан, монгол хүний уужуу тайван занг энэ хотоос олж харна. Наад зах нь зам дээр уралдаж давхилдах, хэн нэгнийхээ урдуур орж бачимдаж түрэмгийлэх нь үгүй. Хүлээцтэй, тайван байх нь биширмээр. Ийм хотод хир халдаамгүй. Энэ хот Улаанбаатарын алдааг давтах ёсгүй гэх бодол төрнө

Дархан хот нь Улаанбаатар, Эрдэнэт хотуудыг бодвол амьдрах болон зорчих зарлага багатай, ажлын байр олдоц ихтэй, цэвэр агаартай, сургууль цэцэрлэгийн хүрэлцээ хангалттай, харилцаа холбоо, гүүрэн гарц, төмөр зам, авто зам зэрэг дэд бүтэц сайтай гээд олон давуу талтай. Түүгээр зогсохгүй энэ хотод олон улсын томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Хамгийн том нь “Найрамдал” төсөл. Европын Холбооны хамтарсан 3 сая еврогийн санхүүжилтийг Дархан хот Төв Азийн бүсээс ганцаараа авч чадсан гээд боддоо. Үүнийг дагаад Улаанбаатарт ч ховорхон болдог томоохон хэмжээний туршлага солилцох олон улсын томоохон форумуудыг Дархан хотдоо төдийгүй Европын Холбооны хотуудад “Найрамдал” төслийн багийнхан хийгээд амжжээ.

Дархан хотыг анх 1961 онд хуучин социалист орнууд болох Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чехословак, Зүүн Герман зэрэг улсын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар байгуулан хөгжүүлсэн түүхтэй.

**“Найрамдал”
төсөл
хэрэгжсэнээр
Европын
Холбоо,
Монгол Улс,
Дархан-Уул
аймгийн
хамтын
ажиллагаа,
хөгжлийн цар
хүрээ тэлэв**

Мөн Япон улсын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтай Дарханы төмөрлөгийн үйлдвэр байгуулагдаж байв. Тус хотод аж үйлдвэр ид хөгжиж, залуус газар бүрээс ирж суурьшин, тэдний итгэл сэтгэл, хөдөлмөрөөр энэ гоё хот бий болсон байдаг. Тиймээс Дарханыг залуусын, найрамдлын хот гэж нэрлэдэг. Тэгвэл Найрамдлын гэх тодотголтой Дархан хот өнөөдөр дэлхийн 14 улсын 9000 хоттой нэгдээд байна. Тодруулбал, “Найрамдал” төслийн буянаар Европын томоохон хотуудтай харилцаа тогтоож, хамтран ажиллах болжээ. Ийнхүү хамтран ажиллах үүд хаалгыг “Найрамдал” төсөл нээж өгсөн байна.

Дархан бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготойгоор Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, ХААИС-ийн Дархан дахь салбар сургууль болон Зүүн өмнөд Европын нутгийн удирдлагын консорциум хамтран 2022 оноос эхлэн гурван жилийн хугацаанд “Найрамдал” төслийг хэрэгжүүлж байна. “Дархан ХААИС”-ийн профессоруудын санаачлан боловсруулж, аймаг орон нутгийн удирдлагын баг дэмжин хэрэгжүүлж байгаа тус төсөл нь Европ Монголын олон талт харилцааг бэхжүүлэх, цахим засаглалыг хөгжүүлэх замаар нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, инновацад суурилсан бизнес эрхлэлтийг дэмжих, тэгш хүртээмжтэй, тогтвортой ногоон эдийн засгийн экосистемийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, тодорхой салбаруудад зорилтот төслүүд хэрэгжүүлжээ. ▶

► Тухайлбал, Дархан-Европын бүс нутгийн форум, Европ-Дарханы инновац, энтрепренершип төвийг байгуулж, ус, хог хаягдал, эрчим хүчний ухаалаг хэрэглээ, хотын ногоон хөгжил болон нийгэм, мэдээллийн технологийн энтрепренершипыг дэмжсэн зорилтот төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах уг томоохон хэмжээний төсөл нь Засгийн газар хоорондын хэлэлцээний замаар бүс нийгмийн институциудын санаачилгаар орон нутагт анх удаа хэрэгжиж буйгаараа онцлог юм.

Төслийн үр дүнд Дархан-Уул аймагт цахим засаглал хөгжиж, засаглалын бодлого боловсруулалтад иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн гэдгийг төсөл хэрэгжүүлэгчид онцолж байна. Төслийн хүрээнд төрийн албан хаагчид, удирдлагуудыг чадавхжуулах олон сургалт, форумыг зохион байгуулжээ. Мөн ухаалаг, ногоон хөгжлийг дэмжсэн зорилтот төслүүдийг дэмжиж, арван аж ахуйн нэгж тус бүрд 20 мянган еврогийн санхүүжилт олгосон байна. Хамгийн том ололт гэвэл, Дархан-Уул аймаг Европын Холбооны гурван хоттой найрамдалт хамтын ажиллагааг үзэглэж, олон улсын байгууллагуудад гишүүнээр элсээд амжжээ. Дархан хот “Найрамдал” төслийн үр шимээр дэлхийн хот болох эхлэлээ ийнхүү тавьсан гэхэд болно.

Европын Холбооны Тогтвортой хотуудын түншлэл хөтөлбөр нь Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудын төвлөрлийг сааруулах, Европын хотуудтай олон талаар хамтран ажиллах санал санаачилгыг дэмжих чиглэлээр хэрэгждэг аж. Европын Холбоо төвлөрлийг сааруулах чиглэлээр бүсчилсэн хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэл рүү илүү их анхаарч буй. Хотууд хамтрах, бие биеэсээ суралцах нь хамгийн зөв гарц гэж үздэг бөгөөд төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутаг хүчтэй байх нь улс орон хөгжих суурь болдог тул Европын Холбооноос хэрэгжүүлдэг аль ч төсөл хөтөлбөрт хамрагдах олон боломж бий болсоор байна.

Ийнхүү Дархан хотын гадаад харилцааг шинэ шатанд гаргахыг бэлгэдэн, Европын хотуудтай урт хугацааны түншлэл бий болгохыг зорьж төслөө “Найрамдал” гэж нэрлэсэн нь ч учиртай. “Орон нутаг хүчтэй байж улс орон хөгжинө” гэсэн Европын хотуудын үзэл санаа Дарханд аль хэдийн биеллээ олсон байна. ■

“Найрамдал” төслийн Дархан-Уул аймагт оруулах хувь нэмэр

Хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Дархан-Европын бүс нутгийн форум байгуулах /ДФЕ/-хамтын ажиллагааны үүлзалт
- Тэргүүн туршлага солилцох форум
- Туршлага судлах айлчлал, солилцооны хөтөлбөр

Иргэдийн оролцоот засаглалыг дэмжих

- Төрийн албан хаагчдыг чадавхжуулах
- Дархан форум байгуулах, Дархан-Уул аймгийн удирдах ажилтан, иргэдийн шуурхай зөвлөгөөн зохион байгуулах
- Ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих цахим засаглалын нэгдсэн платформ бий болгох
- Дархан форумыг сурталчлан таниулах, иргэд олон нийтэд чиглэсэн арга хэмжээ болон нөлөөллийн аян зохион байгуулах

Европ-Дарханы инновац, энтрепренершип төвийг байгуулах

- Нийгэм, технологийн салбарын энтрепренерүүдэд зориулсан ерөнхий болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх
- Энтрепренерүүдэд гарааны хөрөнгө оруулалт, техникийн дэмжлэг үзүүлэх
- Шилдэг энтрепренерийг шалгаруулах
- Вэбсайт болон маркетинг хөгжүүлэлтийн платформ бий болгох
- Европын холбооны улсад энтрепренерүүдийн албан айлчлал зохион байгуулах

Зорилтот төслүүд хэрэгжүүлэх

- Ус, хог хаягдал, эрчим хүчний ухаалаг хэрэглээ, хотын ногоон хөгжлийг дэмжсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх
- Нийгмийн хөгжил болон мэдээллийн технологид суурилсан энтрепренершипыг дэмжсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх

“Найрамдал” төслийг хэрэгжүүлэгч талууд, бүс нутгийн хамтын ажиллагаа



Тоон мэдээлэл



Эх сурвалж: "Найрамдал" төсөл

Фото



"Найрамдал" төслийн удирдлагууд ДЕФ-ын гүйцэтгэх хорооны гишүүн Камлеш Кумар Патакын хамт. 2022.11.05. Станбул хот.



Найрамдал төслийн "Европ, Монголын хотуудын хамтын ажиллагаа" тэргүүн туршлага солилцох форумын үеэр. 2025.02.18. Брюссель хот.



Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга О.Хүрэлчулуунаар ахлуулсан төлөөлөгчдийн баг Дархан Европын бүс нутгийн форумын хамтын ажиллагааны уулзалтын үеэр. 2023.10.04. Станбул хот.



Дархан-Уул аймаг Словени Улсын Аядовшина хоттой харилцан ойлгоцлын санамж бичиг байгуулах үеэр. 2023.11.24. Аядовшина хот.



Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга С.Насанбат тэргүүтэй төлөөлөгчид цэргийн болон шинжлэх ухааны зориулалттай дроны үйлдвэртэй танилцав. 2023.11.24. Аядовшина хот.



Туршлага судлах айлчлалын хүрээнд Дархан-Уул аймгийн Улаан Загалмайн Хороо /УЗХ/-ны хамт олон Итали Улсын Улаан Загалмайн Нийгэмлэг /ИУУЗН/-ийн мэргэжилтнүүд, бусад Европын Холбооны гишүүн орнуудын төлөөлөгчдийн хамт. 2024.11.27. Дархан хот.



"Найрамдал" төслийн удирдлагууд Олон Улсын түншлэлийн хот, бүс нутгууд: Глобал гарцыг нутагшуулах нь форумын үеэр. 2023.11.29. Брюссель хот.



"Найрамдал" төслийн туршлага судлах айлчлалын Европын Холбооны гишүүн орнуудын төлөөлөгчид. 2024.05.29. Дархан хот.

Онцлох ярилцлага

П.Мэнд-Амгалан: Дархан дэлхийн хот болсон



Европын Холбооны төвлөрлийг сааруулах чиглэлээр бүсчилсэн хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэл рүү илүү их анхаарч байна

Европын Холбооны хамтарсан 3 сая еврогийн санхүүжилттэй “Найрамдал” төсөл Дархан-Уул аймагт гурван жил хэрэгжээд дуусах гэж байна. Тус төслийг Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Агроэкологи бизнесийн сургуулийн эрдэмтэн багш П.Мэнд-Амгалан боловсруулж, дэлхийн олон улстай өрсөлдөн шалгарч, Дархан-Уул аймагтаа авчирчээ. Төсөл хэрэгжсэнээр “Олон хүний үзэл бодол өөрчлөгдөхийн дээр 10 гарааны бизнесийг бойжуулж, хөрөнгө оруулахаас гадна давхар олон төслийг бий болгосон. Орон нутагт өөрсдийн санаачилгаар төр, шинжлэх ухааны байгууллага хамтран томоохон төсөл хэрэгжүүлж болж байна. Цаашид бусад аймагтайгаа хамтарч, холбоо байгуулан хөгжих боломж бий” хэмээн “Найрамдал” төслийн удирдагч, Европ-Дарханы Инновац, Энтрепренишип төвийн захирал, доктор П.Мэнд-Амгалан онцолж байна.

-Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн Агроэкологи бизнесийн сургуультай таны ажил амьдрал холбогджээ. Энэ түүхээс ярилцлагаа эхлэх үү?

-Би Завхан аймгийн Тосонцэнгэлийн арван жилийг 1990 онд онц дүнтэй төгссөн. Төгсөөд илгээлтээр нэг жил 350 төллөх хонь авч хариулж байгаад 1991 онд хуучин Гадаад хэлний дээд сургууль одоогийн Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн англи, орос хэлний багшийн ангид суралцаж төгссөн. Бага байхаасаа хэлний хүн болно гэж мөрөөддөг байлаа. Орос хэлний багш нар хөдөө хамгийн гоё хүмүүс байлаа шүү дээ. Бидний үед хэлний ангийн хуваарь маш өрсөлдөөнтэй цөөхөн ирнэ. 10 дугаар ангиа төгсөх жилээ намын даргын хүүхдэд хувиараа алдчихаад нэг жил мал маллаад жилийн дараа зорьсон сургуульдаа орж англи, орос хэлний багшийн мэргэжил эзэмшсэн дээ. 1995 онд сургуулиа төгсөөд Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуульд англи хэлний багшаар ирсэн.

1999 онд харьцуулсан хэл шинжлэлээр магистр хамгаалан, англи хэлний багшаар таван жил ажиллаад 2000 онд энэ сургуульдаа Хүмүүнлэгийн ухааны тэнхимийг байгуулж, Эрхлэгчээр нь ажилласан. 2003 онд Сургалт эрхэлсэн дэд захирал болсон. Арав гаруй жил дэд захирлын албыг хашихдаа боловсролын удирдлагаар Чагнаагийн Пүрэвдорж багш дээр докторт элсэн суралцсан боловч судалгааны ажлаа дуусгаж чадаагүй. Мэдээж цаастай хутгалдаж байгаа хүн судалгааны ажил хийх цаг зав бага, тэр бүр төвлөрч сууж амждаггүй байлаа.

Манай сургууль намайг ажлаа хүлээж авахад 700 гаруй оюутантай байсан, 2008 он гэхэд 2500 оюутантай болтол өргөжсөн. Энэ он жилүүдэд би өөрийгөө бүр умартчихсан байсан. Анх ирж байхдаа 1-2 жил багшилчихаад гадагшаа явах бодолтой байсан хүн чинь бүр шингэчихсэн. Манай монголчууд захирал, дарга эмэгтэй хүнд эр хүнээс илүү хатуу ханддаг бас уйдамтгай талтай. Нэг нэр, хоёр хоч өгнө. Сүүлдээ анзаараад эхэлсэн юм нь нэгдүгээрт, би өөрийгөө бүр хаячихсан байсан. Дотогшоо өнгийдөг, мэдрэмжтэй заримдаа хэдэн шад шүлэг бичдэг, аливаа зүйлд уян хатан ханддаг нээлттэй хүн нэг л ажлын машин шиг болчихсон, хүмүүст хатуу шаардлага тавьдаг, уур уцаартай ▶

► нэгэн болчихсон байсан. Тэгээд л өөртөө завсарлага авахгүй бол болохгүй юм байна гэж шийдээд 2015 онд ажлаа өгөөд 2016 онд буцаад үүргэвчээ үүрээд оюутан болсон доо.

-Хаана ямар мэргэжлээр суралцсан бэ. Ингэж суралцсанаар таны амьдралын өөр нэгэн үүд хаалга нээгдсэн үү?

-Тэгэлгүй яах вэ, хэдийгээр хэлний багш байсан ч олон жил газар тариалан, хүрээлэн буй орчны сургалтын бодлого, хөтөлбөртэй ажилласан болохоор энэ салбартаа сонирхолтой болчихдог юм билээ. Тэгээд БНСУ-ын Инчоны их сургуульд Уур амьсгалын олон улсын харилцааны тэнхимд дөрвөн жил суралцаж, Хүрээлэн буй орчноор докторын зэрэг хамгаалсан. Солонгост докторт 36 кредит үздэг бол миний хувьд мэргэжлийн зөрүү 60 кредит судалж төгссөн. Докторын зэргээ Хог хаягдлын менежментийн чиглэлээр хамгаалсан. Засгийн газрын тэтгэлгээр суралцсан болохоор улс орондоо өртэй юм шиг санагдаад байдаг. Тиймээс орон нутаг, цаашлаад улс орондоо хэрэгтэй зүйл хийхийг үргэлж бодож явдаг.

Намайг 2020 онд БНСУ-д сургуулиа төгсөөд ирэхэд сургууль маань 400 орчим оюутантай болчихсон байсан. Ингээд эрдэм шинжилгээ, гадаад хамтын ажиллагааных нь тал дээр дэм болж, сургуулиа өөд нь татахад тусалъя гээд ковидын хөл хорионы үеэр таван төсөл бичсэн. Улс орнууд Парисын гэрээнд нэгдэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авдаг. Гэтэл энэ бодлого манайд одоог хүртэл хөрсөн дээрээ буугаагүй л байна. Иргэд Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх нь төр, засгийн хийх ёстой ажил бидэнд хамаагүй гэж боддог. Зарим нь энэ тухай ямар ч ойлголтгүй. Одоо л нэг юм орон нутагт төрийн албанаасаа эхлээд ойлголт нэг болж эхэлж байна. Миний бичсэн төслүүд бүгд үүн рүү чиглэсэн.

-Үүнээс “Найрамдал” төсөл бий болох эхлэл тавигдсан уу?

-Дархан-Уул аймгийн хог хаягдлын менежментийн 2032 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг эрдэмтэн судлаачдын баг бүрдүүлээд боловсруулсан. Тэгээд аймгийн Иргэдийн хурлаар батлуулаад хэрэгжихээр болсон. Үүнийг хэрэгжүүлэхэд наад зах нь 60 орчим тэрбум төгрөгийн төсөв хэрэгтэй болж байгаа юм. Бүгдийг нь орон нутгийн төсвөөс гаргана гэхээр боломжгүй.

Төр, шинжлэх ухаан, хувийн хэвшил гурав нягт холбоотой байдаг улс орон хөгжиж байна

Мөнгөгүй бол мянган сайхан төлөвлөгөө байгаад хэрэгжихгүй шүү дээ. Тиймээс яаж мөнгө босгох уу, үүнийгээ хэрхэн ажил хэрэг болгох уу гээд энд тэнд зарласан төсөл хөтөлбөрүүдийг судалж эхэлсэн. Дэлхий дахинаа маш олон боломж байдаг. Европын Холбооны тогтвортой хотуудын түншлэл хөтөлбөрийн хүрээнд ихэнхдээ Латин Америк, Африкийн орнуудыг дэмжиж ирсэн хөтөлбөр байдаг. 200 мянгаас 3 сая хүртэлх еврогийн төслийн тэтгэлэгт уралдааныг зарласан байсныг судалж үзлээ. 2020 онд ковидын хөл хорионы үеэр Инчоны их сургуулийнхаа профессортойгоо мөн Пакистан, Египет, Энэтхэг орнуудын мэргэжилтнүүдтэй хамтран олон улсын цуврал онлайн хурал зохион байгуулсан. Энэ хурлыг хамтран зохион байгуулсан уур амьсгалын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компанийн захирал Энэтхэг хамтрагчдаа “Европын Холбооноос төслийн уралдаан зарлажээ. Хамтарч төсөл бичих үү” гэдэг санал тавьсан. Найз маань зөвшөөрсөн. Тэгээд “Найрамдал” төслийг хамтран бичих ажлаа эхлүүлсэн дээ. Уг нь хог хаягдлын төслийн санхүүжилт хайж байсан боловч хотуудын түншлэл чиглэлийн төсөл рүү ороод явчихсан. Тухайн үед Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлантай уулзаад “Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр энэ төслийг бичлээ шүү, болох уу” гэхэд “болно” гэсэн. Төсөл маань гурван шатны шалгаруулалтад амжилттай тэнцэж шалгарсан. Ингэж л “Найрамдал” төсөл үүссэн түүхтэй.

-Европын Холбооны 3 сая еврогийн санхүүжилттэй. Тийм ч бага хөрөнгө оруулалт биш шүү дээ.

-Европын Холбооны Тогтвортой хотуудын түншлэл хөтөлбөр 2018 оноос хойш хэрэгжсэн. 2021 онд хамгийн сүүлийнхээ уралдааныг зарласан. Энэ хөтөлбөр нь Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудын төвлөрлийг сааруулах, Европын хотуудтай олон талаар хамтран ажиллах санал санаачилгыг дэмжих чиглэлээр хэрэгждэг.

-Энэ төслийг дахин зарлахгүй юм уу?

-Тийм. 2025 оноор дуусаж байгаа. Гэхдээ Европын Холбоо төвлөрлийг сааруулах чиглэлээр бүсчилсэн хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэл рүү илүү их анхаарч байна. Хотууд хамтрах, бие биеэсээ суралцах нь хамгийн зөв гарц гэж үздэг бөгөөд төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутаг хүчтэй байх нь улс орон хөгжих суурь болдог. Тиймээс Европын Холбооноос ►

► хэрэгжүүлдэг аль ч төсөл хөтөлбөрт хамрагдах өөр олон боломж бий.

-Ер нь Найрамдал төсөл яагаад шалгарсан гэж та бодож байна вэ?

-Нэгд, төр, шинжлэх ухаан хамтарсан, төслийн үндсэн агуулга санаа тогтвортой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлсэн нийгмийн институтүүдийг төслийн хүрээнд байгуулахаар бичсэн. Хоёрт, тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ногоон хөгжил, инновац, эмэгтэйчүүд, зорилтод бүлгүүдийг дэмжсэн төсөл. Гуравт, тэгш хүртээмжтэй байдал, Европын сайн хамтрагч түнштэй байх гээд тогтвортой хотуудын түншлэл хөтөлбөрийн зорилгод бүрэн нийцсэн байсан болохоор шалгарсан болов уу. Камлеш зөвлөх маань Зүүн өмнөд Европын нутгийн удирдлагын консорциум буюу ЗӨЕНУК байгууллагатай холбож өгсөн. Уг холбоо нь 14 улсын 9000 хотыг эгнээндээ элсүүлсэн маш том байгууллага юм.

-Төслөө яагаад “Найрамдал” гэж нэрлэсэн юм бэ?

-Дархан хотыг хуучин социалист орнууд болох Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чех, Зүүн Герман зэрэг улсуудын техник, эдийн засгийн тусламжтайгаар “Найрамдлын Дархан” нэрээр байгуулан хөгжүүлсэн. Бид Дархан хотын гадаад харилцааг шинэ шатанд гаргахыг бэлгэдэн, Европын хотуудтай урт хугацааны түншлэл бий болгохыг зорьж төслөө “Найрамдал” гэж нэрлэсэн. Ер нь бол Дархан дэлхийн хот болчихлоо шүү дээ. “Орон нутаг хүчтэй байж улс орон хөгжинө” гэсэн Европын хотуудын үзэл санаа Дарханд бий болж эхэлж байна.

Энэ төсөл хэрэгжихээр гарын үсэг зурах болоход Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал гайхаж байсан. “Буцалтгүй тусламж юм уу, 3 сая евро гэдэг чинь бага мөнгө биш шүү дээ. Энэ зээл биш биз дээ” гээд л дахин дахин асууж байсан.

-Төсөл хэд хэдэн зорилготой хэрэгжиж байгаа юм байна. Ямар зорилтууд дээр төвлөрч ажиллаж байгаа вэ?

-Төслийн зорилтууд маш чухал. Дөрвөн зорилттой. *Нэгдүгээр зорилт нь, Европ Монголын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх,*

Энэ зорилтын хүрээнд Дархан Европын Форум байгуулагдсан. Дархан Европын форум гэхээр нэг удаагийн чуулган, хурал гэж хүмүүс ойлгодог. Гэтэл бид үүнийг нийгмийн институтийн түвшинд

Бид Дархан хотын гадаад харилцааг шинэ шатанд гаргахыг бэлгэдэн, Европын хотуудтай урт хугацааны түншлэл бий болгохыг зорьж төслөө “Найрамдал” гэж нэрлэсэн

оруулаад ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл, олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Европын түнш байгууллагууд, Азийн бүсийн экспертүүд болон Дархан бүс нутгийнхаа төлөөлүүдийг оруулаад форум байгуулж байгаа юм. Дотроо таван дэд хороотой. Форум хэрхэн ажиллах вэ гэхээр Дархан бүс нутагт тулгамдсан асуудлуудыг хэлэлцээд Европын сайн туршлагуудаас санаа авч, санхүүжилттэй төслүүдийг босгон хэрэгжүүлэх зорилготой. Сүүлийн форумыг Бельгид хийлээ. Форумдаа яагаад Европын зүрхэнд очиж хийгээд байна вэ гэхээр Европын санхүүг мэддэг бүх байгууллага тэнд байна шүү дээ. GCoM, UTM, CEMR гэх мэт байгууллагуудын удирдлагуудыг форумдаа урьж оролцуулсан. Бельги дэх манай Элчин сайдын яамныхан “Та нар яаж ийм өндөр хэмжээнд форумдаа зохион байгуулж байна вэ, энэ чухал хүмүүсийг нэг дор цуглуулах тийм амар биш шүү дээ” гэж байсан.

Төслөө бичихдээ нэг л зүйлийг маш сайн бодсон. Монгол Улсад төсөл хэрэгжихээр яг хэрэгжих хугацаандаа сайхан явж байгаад дуусангуут байхгүй болчихдог. Тэгэхээр төслийн тогтвортой байдлыг хэрхэн хангах вэ гэдгийг бодлогоор шигтгэж бичсэн.

Хоёрдугаар зорилт нь иргэдийн оролцоот засаглалыг дэмжих,

Өндөр хөгжилтэй орнуудын хотууд дэргэдээ форумтай байдаг. Тэр форум нь тухайн хотод тулгамдаж буй асуудлуудаа дундаа тавьж байгаад ярилцдаг. Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, судлаач, иргэний нийгмийн байгууллага, иргэн гээд бүх талыг байлцуулж, яг тэр асуудал дээрээ төвлөрч ярилцаад зөв гарц гаргалгаа гаргаж, тэрийгээ орон нутгийн бодлогод тусгаад хэрэгжүүлээд явдаг нийгмийн институтийн түвшинд ажилладаг. Энэ бол шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах сонгодог загвар юм. Дархан форум байгуулагдаад энэ соёлыг орон нутагтаа төлөвшүүлэх зорилгоор төсөл хэрэгжих хугацаанд 10 форум зохион байгуулсан. Нэг форум зохион байгуулахад 5 сая төгрөгийн төсөвтэй. Эхлээд хэцүү байсан зүйл нь аймгийн иргэдийн хуралд хандсан. Сум руу хандсан. “Энэ форумыг аваад яваач ээ, дүрмийг нь боловсруулаад өгчихлөө. Та нарын үйл ажиллагаатай уялдаж байна” гэсэн. Хамгийн гайхалтай нь бие бие рүүгээ шидээд авахгүй байсан. Шүүрч аваад хийх байх гэж бодсон. Нэг л их болгоомжилсон хүмүүс байсан нь сонин. Сүүлдээ ►



► ойлгосон. Зохион байгуулсан Форум болгоноос үр дүн гарсан. Форумдаа аймаг, сумын шийдвэр гаргах түвшний хүмүүсийг оролцуулсан болохоор ямар ч байсан дотроос нь шүүрээд ажил болгоод яваад байдаг юм билээ. Хамгийн сүүлд гэхэд нийгмийн сэтгэл зүйн эрүүл мэндтэй холбоотой форум зохион байгуулсан. Дарханд сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудын нэгдсэн холбоог бий болголоо.

Мөн төрийн албан хаагчдыг чадавхжуулах ажлуудыг хийсэн. Монгол Улсад төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг ганцхан Удирдлагын академи хийдэг. Нэгэн хэвийн сургалтууд л явдаг шүү дээ. НҮБ-аас гаргасан тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд төрийн алба ямар хандлагатай байх, ур чадвар, бодлогын хувьд хэрхэн төлөвшсөн байх вэ гэдэг чиглэлээр төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага байдаг. Энэ гарын авлагыг орчуулж авахыг нь авч, монгол хөрсөн дээр буулгаад 10 модультай сургалтын томоохон хөтөлбөр боловсруулсан. Тэгээд 10 модулиараа 400 орчим төрийн албан хаагчдад сургалт явуулсан.

Мөн энэ зорилтын хүрээнд Ухаалаг хотын концепцийг боловсруулж, эмнэлгийн анхан шатны үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох, IT технологийг нэвтрүүлэх зорилгоор өрхийн эмнэлгүүд, нэгдсэн эмнэлэгт “E-Health” системтэй холбох гэх мэт төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

-Манайхан одоо форум гэхээр л залхах шинжтэй хүлээж авдаг болсон. Монголд форумууд болоод л байдаг, гарсан үр дүн байдаггүйтэй холбоотой байх. Тэгвэл гадаадынхан форум гэдгийг хэрхэн хүлээж авч байна вэ?

“Орон нутаг хүчтэй байж улс орон хөгжинө” гэсэн Европын хотуудын үзэл санаа Дарханд бий болж эхэлж байна

-Асар их ялгаатай. Монголд болж буй форумууд үзэл суртлын өндөр түвшинд зохион байгуулагддаг. Үзэгдэх харагдах байдлаасаа эхлээд супер шүү дээ. Гэтэл Европт зүгээр хурлын өрөө түрээслээд энгийн өдөр тутмын хурал хийж байгаа юм шиг хийнэ. Гэхдээ төлөвлөгөө гаргах, оролцогчдоо сонгох ажил маш нарийн. Тэнд оролцож байгаа хүн болгонд маш өндөр ач холбогдол өгч хамгийн чанартай мэдээллүүдээ солилцдог. Төслийн хүрээнд тэргүүн туршлага солилцох 12 удаагийн форум зохион байгуулахаас зургаа нь Монголд, зургаа нь Европт зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын 19-25-нд Испанийн Мадридад “Испани Монголын ухаалаг хотуудын бизнес түншлэл” сэдвийн хүрээнд форум хийсэн. Мэдээллийн эрин зуунд хамгийн чанартай, чухал мэдээллийг нэг дороос авна гэдэг бол маш чухал. Гол нь сайн туршлагуудыг хуваалцах нь юу юунаас илүү үнэ цэнтэй. Синхрон орчуулгатай явдаг. Ач холбогдол өгч оролцож байгаа хүмүүсийн хандлага илт анзаарагддаг. Өөрчлөлтөд хэдий чинээ олон хүн өртөнө, төдий чинээ хөгжил хурдасна.

Одоо Дарханд гоё экосистем бий болж эхэлж байна. Ялангуяа хүний харах өнцгийг өөрчилнө гэдэг тийм амар ажил биш шүү дээ. Манайхан танилцуулах презентацидаа бүх анхаарлаа хандуулдаг, эсвэл хэтэрхий сунжирсан илтгэлүүд тавьдаг, хамгийн чухал хэсэг нь болох хэлэлцүүлэгтээ ач холбогдол өгдөггүй, уйтгартай байдлаар хэлбэр төдий хийдэг. Тиймээс форумууд үр дүнгүй болоод байгаа юм.

-Энэ төсөл ер нь хүний тархи руу их ажилласан юм байна. Тийм үү?

-Тийм шүү. Аймаг орон нутгийн удирдлагууд, ►



► төрийн алба хаагчид, бизнес эрхэгчид гээд 2000 гаруй хүн чадавхжуулах сургалтуудад хамрагдах, солилцооны хөтөлбөрт оролцох, бизнес айлчлал хийх гэх мэтээр төслийн үйл ажиллагаанд хамрагдаж өөрчлөлт шинэчлэлийн давалгаанд өртсөн гэж дүгнэж болно. Энэ өөрчлөлтөд хамгийн их өртсөн хүн бол Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа. Тэрбээр "Найрамдал" төслийн Засаг даргын Тамгын газрын төслийн нэгжийн захирлаар ажилладаг. Тиймээс энэ төсөл эхэлсэн цагаас хойш унага шиг дагасан даа. "Онц сурлагатан" гэж хэлэхэд гадныхны сайн туршлагаудаас сайн суралцаж ажил хэрэгтээ нэвтрүүлдэг хүн. Хэрхэн чамбайрч, хөгжиж байгаа нь нүдний өмнө ил байдаг.

-Зүүн өмнөд Европын нутгийн удирдлагын консорциум буюу ЗӨЕНУК байгууллагатай төслийн хүрээнд хамтран ажиллаж байгаа. Энэ байгууллагаас ямар туршлагаудыг авч хэрэгжүүлж байгаа вэ?

-ЗӨЕНУК (Зүүн Өмнөдийн Европын нутгийн удирдлагын консорциум) нь 14 улсын 9000 хотуудын нэгдсэн холбоо. Хотууд хамтарч хөгждөг том платформ. Бид энэ туршлагыг Монголд нутагшуулах зорилгоор Монголын Үндэсний хотуудын удирдлагын нэгдсэн холбоо Монголын хотуудын холбоог байгуулсан. Даргаар нь Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа ажилладаг. Дархан-Уул аймаг бусад аймагтайгаа хамтарч, аймаг хотоо хөгжүүлэх боломж бий болж байна гэсэн үг. Уур амьсгал, эрчим хүчний асуудлаар нэгдсэн дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээртэй хамтран энэ зургаадугаар сарын 3,4,5-ны өдрүүдэд Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах арга аргачлалын талаар хотуудын холбооны гишүүдэд сургалт явуулахаар төлөвлөж байна. Энэ төлөвлөгөө ямар ашигтай вэ гэхээр олон улсын стандартын дагуу боловсруулбал уур амьсгалын

Бид энэ туршлагыг Монголд нутагшуулах зорилгоор Монголын Үндэсний хотуудын удирдлагын нэгдсэн холбоо Монголын хотуудын холбоог байгуулсан

өөрчлөлтийг сааруулах чиглэлээр хөрөнгө оруулалт татах үндсэн бодлогын баримт бичиг болох юм.

Хотууд, бүс нутгууд гаднын санхүүжилт авахад тогтвортой хөгжлийн 17 зорилгыг нутагшуулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэсэн байх хэрэгтэй юм. Дээрх хоёр агуулгаар бичсэн төсөл санхүүжилт авах өргөн боломжтой. Бусад аймаг, хот үүнийг мэддэг байх хэрэгтэй.

-“Найрамдал” төсөл гурван жилийн хугацаанд хэрэгжихдээ ямар үр дүн авчирсан бэ?

-Олон үр дүнг дурдаж болно. Ярьж дуусахгүй ээ. Дархан хот Уур амьсгал, эрчим хүчний асуудлаар нэгдсэн дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээрт элссэн. Уур амьсгал, эрчим хүчний асуудлаар нэгдсэн дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээр, Хотын шилжилтийн хөтөлбөр, Зүүн Азийн хотуудын холбоонд элссэн. Дэлхийн хотуудтай мөр зэрэгцэн хөгжих үүд хаалга нээгдэж байна. Эдгээр холбоонд элссэнээр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулахад хотын удирдлагууд үүрэг хүлээж, бодлогоо үүнтэй уялдуулна гэсэн үг. Энэ хүрээнд уурын зуухнуудаа нурааж эхэлсэн, яндангийн тоог цөөлөх, нийтийн тээврээ электрон болгох гээд шилжилт өөрчлөлтүүд хийж эхэлсэн. Ухаалаг хотын концепцийг боловсруулсан. Асуудлаа олж харж, шийдвэрлэх арга замаа тодорхойлсон хотыг ухаалаг хот гэдэг юм байна. Ухаалаг хот нь ногоон, байгаль болон хүндээ ээлтэй, хүн нь эрүүл, аюулгүй, боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ тэгш хүртээмжтэй, хамгийн бага хүлэмжийн хий ялгаруулдаг хот байх ёстой гэдгийг ойлгосон. Мэдээж ийм болох нь алга урвуулахтай адил амархан зүйл биш хэдий ч Дархан-Уул жишиг, ухаалаг аймаг болохоор зорин ажиллаж байна. Мөн гарааны бизнесүүдийг дэмжих ажлын хүрээнд Дархан-Уул аймагт үндсэн 41, улирлын 48 чанартай ажлын байр шинээр бий болсон.

-Гарааны 10 бизнесийг бойжуулж, хөрөнгө оруулалт хийсэн гэж байна. Одоо эдгээр бизнес хэр амжилттай явж байгаа вэ?

-Энэ ажил төслийн маань гуравдугаар зорилтын хүрээнд хийгдсэн. Уг төслийн автор нь манай их сургууль. Манайд бизнес хөгжихгүй, судалгаа шинжилгээний байгууллагуудын чадавх нэмэгдэхгүй байгаагийн гол шалтгаан нь үйлдвэрлэл, сургалт хоёр уялдаж чадахгүй байгаа юм. Төр, шинжлэх ухаан, хувийн хэвшил гурав ►

► нягт холбоотой байдаг улс орон хөгжиж байна. Тиймээс бид Дархан-Уул аймагтаа инновац, гарааны бизнесийн экосистемийг бий болгохоор ажиллаж байна. Энэ хүрээнд сургуулиа түшиглээд Европ-Дарханы Инновац, Энтрепренершип төвийг байгуулсан. Тус төв арван гарааны бизнесийг бойжуулж байна. Гарааны бизнес гэхээрээ мэдээлэл, технологийн чиглэлээр хөгждөг гэсэн ойлголт байдаг. Бид салбар салбарын дэвшилтэт технологи бүхий гарааны бизнесүүдийг хөгжүүлэхээр зорьж байна. Манай арван гарааны бизнес дотор био нүүрс гаргаж, хөрсөн бортогонд хийгээд ургамлын амьдрах чадварыг эрс сайжруулж байгаа бизнес бий. Өндөгний бизнес гэхэд тахианы сангас нь хаягдахгүй тойргийн эдийн засгийн зарчмыг хангаж байгаа юм. “Найрамдал мөөг” гээд ухаалаг хүлэмжтэй мөөгний аж ахуйг гарааны бизнесээр байгуулсан. Ухаалаг зоорины бизнес автомат хяналтын системтэй. Хадгалалтын горимыг зохицуулна гэсэн үг. “Ихэр дөл” утаагүй зуухыг гаргаж ирсэн. Үнэхээр сайн зуух байгаа. Японы мэргэжлийн сумогийн их аварга Харумафүжигийн сүүний ферм энэ зуухаар халаалтаа шийдсэн. Одоо энэ зуухны бизнес дараагийн хөрөнгө оруулалтаа авах гээд явж байна. Манай их сургууль дээр Science Cafe байгуулагдсан. Энд хүмүүс кофе уухаас гадна анги хамт олон, гэр бүлээрээ ирж шинжлэх ухааны туршилтуудыг хийх боломжтой. Мөн боломжийн өртөгтэй, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц гээд олон чиглэлийн гарааны бизнесүүдийг бойжуулж байна.

Анх эхэлж байхад үйлчлүүлэгчид маань уламжлалт бизнес гарааны бизнес хоёрын ялгааг ч мэдэхгүй, өөрсдөө төсөл бичиж мэдэхгүй, компанийн засаглалаа ч ойлгохгүй, бизнесийн төлөвлөгөөгөө гаргах мэдлэггүй байсан. Тиймээс бид бизнесүүдээ чадавхжуулах сургалтуудыг шат дараатай зохион байгуулсан. Эхнээс нь авхуулаад бас толгойтой нь ажиллаж байгаа юм. Төсөл бичих аргачлалыг нь зааж өгч, санаануудыг нь хөгжүүлж байгаад шалгаруулсан. Шалгарсан арван гарааны бизнестээ тус тусад нь 70 сая төгрөгийн буцалтгүй тусламж болон инкубацийн үйлчилгээ үзүүлж байна. Мөн Турк, Словени, Хорват, Брюссель рүү авч явж туршлага судлуулж, салбар салбараар нь сургалт зохион байгуулсан. Ази, Европ, Африкт том том бизнесүүдийг босгоод ирсэн туршлагатай менторуудыг Европоос авчирч бизнес эрхлэгчдэдээ сургалт явуулж байна. Мөн Монголынхоо тухайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн экспертүүдийг

урьж хичээл заалган, хурдасгуур хөтөлбөртөө хамрууллаа. Төсөл дууссан ч энэ төв маань цаашид үйл ажиллагаагаа тогтвортой хадгалаад явна.

–“Найрамдал” төслийн хүрээнд Дарханд мэдээллийн технологийн дэвшлийг шингээсэн төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, хотын дэд бүтэц дээр тулгамддаг асуудлуудаас ногоон хөгжил мэдээлэл технологийн болон “ноу хау” шингээсэн төслүүдийг хэрэгжүүлэх зорилго мөн явж байгаа юм байна. Энэ хүрээнд юу хийсэн бэ?

–Төслийн маань дөрөвдүгээр зорилтын хүрээнд хотын дэд бүтэц, нийгмийн дэд бүтцийн гурав, гурван туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн. Нийт 700 гаруй сая төгрөгийн 6 зорилтот төсөл хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах “Жишиг хороолол”, ухаалаг худаг, гэр хорооллын дахин төлөвлөлт, “Home Center” СӨХ-ны менежментийг сайжруулах төсөл, Дархан-Уул аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө боловсруулах D-CAMP төслүүдийг дурдаж болно.

–Та ер нь хэдэн төсөл бичсэн хүн бэ?

–Миний данстай найман төсөл бий. Европын Холбооны санхүүжилттэй 5, ЖАЙКА-гийн 1, Солонгосчуудтай хамтарч хэрэгжүүлдэг 2 төсөл байна. Ихэнх нь дээд боловсролын байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, сургалт судалгааны орчны сайжруулах төслүүд. Орон нутагт Олон улсын төсөл хэрэгжүүлдэг сургууль цөөхөн шүү дээ. Манай сургууль дээр нийт Олон улсын 13 төсөл хэрэгжиж байна.

–Европын Холбоо Төслийн хэрэгжилтийн үр дүнг хэрхэн дүгнэж байгаа вэ?

–Төсөл хэрэгжих хугацаанд жил бүр дотоодын болон Европын Холбооны аудит орж байсан. Мөн Европын талаас хөндлөнгийн үнэлгээг нэг удаа хийсэн. Бид маш сайн үнэлгээ авсан. Төслийн төлөвлөгөөнөөс хазайлгүйгээр явахад ямар ч асуудал байхгүй дээ. Энэ төслийг 3 сая еврогийн хөрөнгө оруулалтыг Дархан-Уул аймагт хийж байгаа ч гарах үр дүн нь 10 сая еврогийн тэлэлтийг бий болгоно гэсэн зорилготойгоор бичсэн. Тиймээс энэ төслийн хүрээнд бид найман төслийг боловсруулж Олон улсын байгууллагууд руу явуулсан. Дээр дурдсан төслүүдээс гадна томоохон өөр нэг төсөл энэ жил хэрэгжих гэж байна. Тэр нь Карбон маркет буюу нүүрстөрөгчийн зах зээл дээрээс анхны хөрөнгө оруулалтыг босгох гэж байна. Энэ бол Монгол Улсад, манай аймагт маш чухал хэрэгцээт төсөл байх болно. ■

Миний данстай найман төсөл бий. Европын Холбооны санхүүжилттэй 5, ЖАЙКА-гийн 1, Солонгосчуудтай хамтарч хэрэгжүүлдэг 2 төсөл байна

“Найрамдал”-ын үр шим

Дархан 14 улсын 9000 хоттой нэгдэв



“Найрамдал” төсөл хэрэгжсэнээр Дархан-Уул аймаг Европын холбооны хотуудтай хамтарч ажиллахаас гадна, олон улсын олон байгууллагатай хамтрах эхлэлээ тавьсан. Жишээлбэл, Дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээрт элсэхээс гадна Хотын шилжилтийн хөтөлбөрт албан ёсоор элсэв. Мөн Зүүн Азийн хотуудын холбоонд элсжээ. Ингэснээр дэлхийн хотуудтай мөр зэрэгцэн хөгжих үүд хаалга нээгдсэн гэхэд болно. Эдгээр холбоонд элссэнээр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулахад хотын удирдлагууд үүрэг хүлээж, бодлогоо үүнтэй уялдуулна гэсэн үг. Энэ хүрээнд уурын зуухнуудаа нурааж, яндангийн тоог цөөлөх, нийтийн тээврээ электрон болгох зэрэг шилжилт өөрчлөлтүүд хийгдэж эхэлсэн байна. Мөн ухаалаг хотын концепцийг боловсруулжээ. Асуудлаа олж харсан, шийдвэрлэх арга замаа тодорхойлсон хотыг ухаалаг хот гэх бөгөөд ногоон, байгаль болон хүндээ ээлтэй, хүн нь эрүүл, аюулгүй, боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ тэгш хүртээмжтэй, хамгийн бага хүлэмжийн хий ялгаруулдаг хот байх ёстой гэдгийг

төсөл хэрэгжүүлэгчид онцолж байв. Мэдээж ийм болох нь алга урвуулахтай адил амархан зүйл биш хэдий ч Дархан-Уул аймаг жишиг, ухаалаг аймаг болохоор зорин ажиллаж байгаа юм.

Аймаг орон нутгийн удирдлагууд, төрийн алба хаагчид, бизнес эрхэгчид гээд 2000 гаруй хүн чадавхжуулах сургалтуудад хамрагдах, солилцооны хөтөлбөрт оролцох, бизнес айлчлал хийх гэх мэтээр төслийн үйл ажиллагаанд хамрагдаж өөрчлөлт шинэчлэлийн давалгаанд өртсөн байна.

“Найрамдал” төслийн хамгийн том хамтрагч бол Зүүн өмнөд Европын нутгийн удирдлагын консорциум юм. ЗӨЕНУК нь 14 улсын 9000 хотыг эгнээндээ нэгтгэсэн нэгдсэн холбоо бөгөөд хотууд хамтарч хөгждөг том платформ.

Энэ туршлагыг Монголд нутагшуулах зорилгоор Монголын Үндэсний хотуудын удирдлагын нэгдсэн холбоо /NALAM/-г байгуулжээ. Даргаар нь Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа ажилладаг бөгөөд Дархан-Уул аймаг бусад аймгуудтайгаа хамтарч, аймаг хотоо хөгжүүлэх боломжийг бий болгохоор зорин ажиллаж байна. ■



Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал тэргүүтэй төлөөлөгчдийг Хорват Улсын Риека хотын дарга Марко Филипович хүлээн авч уулзсан уулзалтын үеэр. 2022.11.02. Дархан хот.



Дархан-Уул аймгийн Засаг Даргын Тамгын газар, ХААИС-ийн салбар Агроэкологи Бизнесийн сургууль болон Инчон Инновацийн Кластерууд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах үеэр. 2023.11.02.

ТӨСЛИЙН ХАМТРАГЧИД, ХАРИЛЦАГЧИД

ОЛОН УЛС					
1	Словени улсын хотуудын холбоо	51	Топспаре партс ХХК	105	Улаан загалмайн нийгэмлэг
2	Монтенегро улсын хотуудын холбоо	52	Сарлагийн Бух ХХК	106	Дархан Төмөрлөгийн үйлдвэр
3	Европын хот, бүс нутгийн зөвлөл	53	Гөү кэйр ХХК	107	Дархан Дулааны цахилгаан станц
4	Мармара хотын захиргаануудын холбоо	54	Окто Этван ХХК	108	Өег гурил ХХК
5	Словени улсын Аядовщина хот	55	Эдүкэйтэд энтерпрайз ХХК	109	Херо хүдэр ХХК
6	Хорват Улсын Риека хот	56	Технож Инкубатор ХХК	110	Бат Бүрэн Толгой ХХК
7	Монтенегро улсын Бар хот	57	Эрүүл бяцхан иргэд ТББ	111	Сатурн Экстрим Монголиа ХХК
8	"Харилцан туршлага солилцсон улс орон: Словени, Хорват, Монтенегро, Серби, Турк, Итали, Испани, Япон, Хятад, Өмнөд Солонгос, Энэтхэг, Грек, Финланд, Норвег, Нидерланд, Болгар, Бельги, Умард Македон"	58	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт	112	Гэрэлт ган үзэг ТББ
		59	Иргэний нээлттэй боловсрол ТББ	113	БСБ Электроникс ХХК
9	Инчон Инновацын Кластер	60	Боловсролын санаачилгууд ТББ	114	Дархан Сити электрон ХХК
10	Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн засаг захиргаа	61	Ноён Капитал ХХК-Амар зочид буудал	115	Чингис хаан банкны Дархан 01 салбар
11	Эрчим хүч, уур амьсгалын асуудлаар нэгдсэн дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээр	62	Тоёоко инн зочид буудал	116	Дөлдөрвөн хүчтэн ХХК
12	Хотын шилжилтийн хөтөлбөр	63	Бисофт интернэшнл ХХК -Гайд зочид буудал	117	Суран цагаан ХХК
13	БиФлат Сервис ХХК	64	Санко маркетинг Монголиа ХХК	118	Артгэр медиа групп ХХК
14	Грийнвөркс Консалтинг ХХК	65	Мөнхбат-Оршихуй ХХК	119	Их мориг ХХК
15	Ворлд Трэйд Линк компани	66	Модон завь ХХК	120	Ихэр алтан дөл ХХК
16	Ои ДМЕ Солюшнс ХХК	67	Эжайл төслийн удирдлагын төв ТББ	121	Их хаан бугуйвч ХХК
МОНГОЛ УЛС		68	Mongolian Economy сэтгүүл	122	Тийм көүчинг Монгол ХХК
17	УИХ-ын гишүүд	ДАРХАН-УУЛ АЙМАГ		123	Грийн вүүд кравт ХХК
18	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	69	Дархан-Уул аймгийн ИТХ	124	Хос Анар ХХК
19	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	70	Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ	125	Мөнххязгааргүй ХХК
20	Эдийн засаг, хөгжлийн яам	71	Дархан-Уул аймгийн Дархан сумын ЗДТГ	126	Сайн орших ХХК
21	Сангийн яам	72	Шарын гол сумын ЗДТГ	127	Мөнх тэнгэр студий ХХК
22	Гадаад харилцааны яам	73	Хонгор сумын ЗДТГ	128	Хар халбагат ХХК
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	74	Орхон сумын ЗДТГ	129	Бат энэрэл сондор ХХК
24	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	75	Онцгой байдлын газар	130	Тохь комплекс ХХК
25	Төв аймгийн ЗДТГ	76	Цагдаагийн газар	131	Номадс хоспиталити ХХК
26	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	77	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс	132	Хайраас өвлөх хайр НҮТББ
27	Өвөрхангай аймгийн ЗДТГ	78	Нийгмийн бодлогын хэлтэс	133	Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо НҮТББ
28	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн	79	Санхүү, төрийн сангийн хэлтэс		
29	Стартап маркетинг спэйс ХХК	80	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс	134	Шинжлэх ухааны Академийн дэргэдэх Монголын шинжлэх ухааны салбарын манлайлагч эмэгтэйчүүд холбоо ТББ
30	Монголын улсын шинжлэх ухааны академи	81	Соёл урлагийн газар		
31	Монгол Улсын шинжлэх ухаан технологийн их сургууль	82	Боловсролын газар	135	Жаргалантын Хавчиг ХХК
32	Санхүү, эдийн засгийн их сургууль	83	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	136	Шар зам ирээдүй хоршоо
33	МУИС Инженер технологийн сургууль	84	Биеийн тамир спортын газар	137	Номин трэйд ХХК
34	Жийжүү-Оргил ХХК	85	Хүнс, хөдөө аж ахуйн газар	138	Газар буудай ХХК
35	Урам Үндэр ХХК	86	Байгаль орчны газар	139	Гранд яак ХХК
36	Аэр Маркет ХХК	87	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	140	МОНБЗ продакшн ХХК
37	Мобиком ХХК	88	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	141	Саран-Элит ХХК
38	Флай саунд ХХК	89	Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар	142	ХОС-ДОГ ХХК
39	Ирээдүйгээ аврах хөдөлгөөн ТББ	90	Дархан хотын соёл амралтын хүрээлэн	143	Дархан БАСУ ХХК
40	Импакт Про ХХК	91	Орон нутгийн өмчийн газар	144	"Найрамдал мөөг" хоршоо
41	Залуу судлаачдыг дэмжих сан ТББ	92	Дархан хотын тохижилт, үйлчилгээний газар	145	Ухаалаг зоорь төслийн баг /Ж.Байгалмаа/
42	Монголын гайд түр ХХК	93	Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ	146	Тэс оргил ХХК
43	Технологи инновацыг дэмжих санаачлага ТББ	94	Дархан-Уул аймгийн Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ	147	ACT4 Darkhan төслийн баг / П.Содгэрэл/
44	АЙ СИ ТИ ГРУПП ХК	95	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	148	Дархан Фокус ТББ
45	Хангайн сонор ХХК	96	12 дугаар сургууль, 31-р сургууль 6-р анги, 9-р сургууль 5 болон 10-р анги,	149	Дархан хоггүй ирээдүй ТББ
46	Сапиожен ХХК	97	4 ба 7 дугаар цэцэрлэг	150	Данда солишн ХХК
47	Ориентал сэвор ХХК	98	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	151	Гэрэлт эрдэм цацрах НҮТББ
48	Метафорс ХХК	99	Худалдаа аж үйлдвэрийн танхим	152	Нью Тур Сафарис ХХК
49	КЭЙ ДИ ХХК	100	ШУТИС Дархан салбар	153	Баялаг аж уул ХХК
50	Өгөгдөл, шинжилгээ, загварчлалын төв ТББ	101	АШУУИС Дархан салбар	154	Агаруутын охин ХХК
		102	ХААИС Дархан салбар	155	Гэрэлт амжилтын түлхүүр ХХК
		103	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Дархан салбар	156	Батханжаргалант ХХК
		104	Дархан политехник коллеж		

Зөвлөх

Камлеш Кумар Патак: Дархан хот Европын Комиссын “Дэлхийн Гарц” санаачилгатай хамтран ажиллах гүүр болно



"Грийнвөкс консалтинг" компанийн үүсгэн байгуулагч, захирал, "Найрамдал" төслийн ДЕФ-ын гүйцэтгэх хорооны гишүүн Камлеш Кумар Пататай ярилцлаа.

-Та Монгол Улстай, тэр тусмаа Дархан-Уул аймагтай хэрхэн холбогдож байсан бэ?

-Би Монгол Улстай тун сонирхолтой нөхөрлөлөөр дамжин холбогдсон. Саад тотгорыг үгүй хийх замаар улс орны, хүмүүсийн хөгжил цэцэглэлт, аз жаргал, хүч боломжид хувь нэмрээ оруулах хүсэлтэй минь энэхүү нөхөрлөл холбоотой. Би хэзээ ч арилжааны зорилгоор ажилд ханддаггүй. Харин байгууллага, хувь хүнийг дэмжихийн тулд өөрийн бүхий л мэдлэг, ур чадвар, танилын сүлжээг ашигладаг.

Би ХААИС-ийн Дархан дахь салбар сургуулийн Гадаад харилцаа хариуцсан захирал, профессор П.Мэнд-Амгалантай БНСУ-ын Сонгдо

хотод анх уулзаж байлаа. Тухайн үед би БНСУ-ын Инчоны үндэсний их сургуульд Хотыг өөрчлөхөд цэвэр технологи, инновацыг ашиглах нь сэдвээр лекц уншихаар уригдаад байсан юм.

Түүнтэй уулзсаны дараа би Дархан хот, Монгол Улсад ихээхэн нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрийг бий болгох боломжуудыг түүнд санал болгосон. Тэдгээр боломжийн нэг нь Европын Комиссын сонгон шалгаруулалтад оролцох байлаа. Би бусад улсын өргөдөл өгөх процесст тусалж байсан ч П.Мэнд-Амгалан профессор, Дархан-Уул аймгийн удирдлагын хүсэл тэмүүллийг дэмжин Дархан-Уул аймагтай хамтран ажиллахаар сонгосон юм.

Монгол Улс, Дархан хотын иргэд, тэр дундаа Засгийн газарт ажилладаг маш олон хүнтэй үүсгэсэн гайхалтай нөхөрлөл, харилцан хүндлэлийн үр дүнд би Монгол Улстай маш дотно харилцаатай болжээ. Ажлын байр, эдийн засгийн боломж, институтүүдийн чадавхыг бэхжүүлэх мөн өөрчлөлтийг авчрагч болно, өөрчлөлт хийж чадна гэсэн үзэл бодлыг төрийн байгууллагын ажилтнууд, шийдвэр гаргагч нарт суулгаж чадсан гэдгээрээ би ихэд бахархдаг. Хамтдаа хийж бүтээж буй зүйлээр бахархаж, нүүрэндээ баяр хөөр тодруулан надтай уулздаг монгол анд найзууд маань надад асар их баяр хөөр, аз жаргалыг мэдрүүлдэг.

-“Найрамдал” төсөл бий болж, хэрэгжихэд таны оролцоо, хичээл зүтгэл их бий. Таны энэ төсөлтэй холбогдож, хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байгаагийн гол шалтгаан,

зорилго юу вэ?

-Би энэ төслийг ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь сургууль, Дархан-Уул аймгийн удирдлага, Дархан хотынхон төдийгүй олон монгол найзынхаа төлөө хийж байна. Буян үйлдэхийг амьдралын зорилгоо болгодог Энэтхэгийн уламжлал, соёл иргэншил, мөн эцэг эхийн өгсөн хүмүүжлээс бусдад тус болох энэхүү хүсэл тэмүүлэл маань надад бий болсон гэж болно.

Монгол, Ази болон Европ тивд байгаа хамтрагчид, найз нөхөдтэйгээ хамтран ажиллаж байгаагаа би хамтын ажиллагаа, нөхөрлөл, хөгжил цэцэглэлтийн төлөө оруулах ёстой үүрэг хариуцлагаа гэж үздэг. Дархан хот дахь мундаг хамтрагчдынхаа ачаар би Монгол Улсын 21 аймаг, Дархан-Уул аймгийн дөрвөн сум, Төвийн бүсийн гурван аймагт төсөл хэрэгжүүлж чадсанаа дурдахад баяртай байна.

Түүнчлэн Европын маш олон хот, бүсийг Дархан хоттой ах дүү хотын харилцааг үүсгэх, хамтын ажиллагааг эхлүүлэх үүд хаалгыг энэ төсөл маань нээж өглөө. Үүгээр зогсохгүй олон тооны их сургууль, бизнесийн байгууллага, инновацын экосистемийн оролцогчид, мөн Европын улсуудын иргэд ч энэ төслийн үр шимийг хүртэж байна. Монгол, Европын олон байгууллага хамтарч ажилласны үр дүнд уг төсөлд хамрагдах өргөдлөө Дархан хот өгсөн. Техникийн болон санхүүгийн удирдлагыг онцгой сайн хэрэгжүүлж, үлгэр дуурайл болохуйцаар дэмжиж ажилласанд нь би маш их талархаж байна.

Зөрчил, сул дорой байдал бус харин хамтрал, хамтын ажиллагаа, ►

► зөвшилцөл, хамтдаа хөгжих нь энх тайван, эв нэгдэлд хүргэх гол хүчин зүйл гэдэгт би итгэдэг. Миний зорилго бол Европын холбоотой хамтарсан санхүүжилтээр Дарханд эхлүүлсэн 6 туршилтын төсөл, 10 старт-апыг улам өргөжүүлэх, Европын болон бусад түнштэй хамтран хөрөнгө оруулалт татах боломжтой улам олон төсөл, стартапуудыг бий болгох явдал юм.

-Энэ төслийн зорилго, алсын хараа, үр дүн, Европын холбоо, Монгол Улс, Дархан-Уул аймгийн хамтын ажиллагаа, хөгжлийн цар хүрээг та хэрхэн харж байгаа вэ?

-Европын холбоо, Монгол Улс, Дархан-Уул аймгийн оролцогчдын хооронд урт хугацааны бодлогын болон үйл ажиллагааны замын зураг гаргах ёстой гэж бодож байна. Монгол Улс болон Европын холбооны хооронд төвлөрлийг сааруулах чиглэлээр өрнүүлж буй хамтын ажиллагааны бат бөх суурь төдийгүй бүс нутаг хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог “Найрамдал” төсөл бий болгож байна. Тэр дундаа Дархан хот нь итгэл найдварын гэгээ, Европын Комиссын “Дэлхийн Гарц” санаачилгатай хамтран ажиллах гүүр болох юм.

Европын маш олон хот, бүс нутагтай хамтран ажиллах замаар “Найрамдал” төсөл нь Монгол Улс болон Словен, Хорват, Монтенегро улсын Айдовчина, Рьека, Бар хотуудын хоёр талт хамтын ажиллагаанд боломж, хамтын харилцааны шинэ сэдвийг гаргаж ирсэн гэж болно. Үүнд мөн бусад улсын хотууд ч нэмэгдэнэ.

-Төслийн үндсэн бодлого болох цахимжилт болон ногоон хөгжлийн бодлого төсөл хэрэгжих хугацаанд хэрхэн биеллээ олсон гэж та харж байгаа вэ?

-“Найрамдал” төслийг Европ болон Дархан хотын хоорондох бүс нутгийн хамтын ажиллагаанд тулгуурлан төлөвлөсөн. Уг төсөл нь сайн засаглал, нийгмийн хүртээмж,

Дархан хот дахь мундаг хамтрагчдынхаа ачаар би Монгол Улсын 21 аймаг, Дархан-Уул аймгийн дөрвөн сум, Төвийн бүсийн гурван аймагт төсөл хэрэгжүүлж чадсанаа дурдахад баяртай байна

тогтвортой байдал, ногоон хөгжил, хөгжил цэцэглэлт, инновацад төвлөрөх замаар бүс нутгийн хөгжлийн загвар аргачлалыг санал болгож байгаа юм. “Найрамдал” төсөл нь зөвхөн дижиталчлал, ногоон хөгжлөөс гадна маш олон зүйлийг хийж хэрэгжүүлсэн. Бид тогтвортой хотуудын олон талт асуудлыг шийдвэрлэх зорилгоор Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хороо, болон 6 дэд хороо хороог байгуулсан.

Ердөө гурван жилийн хугацаанд бид ногоон хөгжил, ухаалаг хот, дижиталчлал, тогтвортой бөгөөд ногоон санхүүжилт, хямд өртөгтэй орон сууц, Тогтвортой хөгжлийн зорилгуудыг нутагшуулах, хот хоорондын хамтын ажиллагаа, тэсвэртэй хот зэрэг сэдвээр олон ажил хийжээ. Бид зөв чиглэлд урагшилж байгаа гэдгийг хариуцлагатайгаар мөн бат итгэлтэйгээр хэлэхийг хүсэж байна. Дархан хот болон Монголын бусад аймгийг чадавхжуулах, техникийн тусламж болон санхүүжилт үзүүлэх тал дээр бидний үйл ажиллагаа, зорилго бүхэн дунд болон ахисан түвшинд хүрсэн.

-Инновац шингэсэн ногоон, тогтвортой хөгжлийн бодлогыг хангах гарааны бизнесүүдийг “Найрамдал” төсөл дэмжсэн. Мөн зарим төслийн цаашдын санхүүжилтийг бий болгоход таны туслалцаа маш их байгаа гэж сонссон. Та цаашид төслийн хүрээнд болон Монгол Улстай хэрхэн хамтарч ажиллах вэ. Төлөвлөгөө бий юу?

-Сүүлийн гурван жилд би Дарханы, Монголын олон найз нөхөдтэйгээ нягт хамтран ажиллажээ. Тэдний нээлттэй, нөхөрсөг зан, эх орныхоо эдийн засгийг хөгжүүлэх чин хүсэл эрмэлзэл нь үнэхээр бахархмаар санагддаг. Монгол Улс ихээхэн өөрчлөлтийг туулж, эдийн засгийн өсөлтийг хурдасгах хүсэлтэй эх оронч улстөрчид улам олширч байна. Монгол Улс хөгжлийн шинэ үе шатанд хөл тавьж байгаа гэж бодож байна.

Дашрамд дурдахад, бид орон нутгийн удирдлага, хувийн хэвшилд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, техникийн туслалцааг нэмэгдүүлж байгаа бөгөөд цаашид “Найрамдал” төслийг үргэлжлүүлэн дэмжинэ. Бид Монголын Үндэсний хотуудын удирдлагын нэгдсэн холбоо (NALAM), “Найрамдал” Шинжлэх ухааны хааб (FSH) хэмээх хоёр шинэ байгууллагыг санаачилсан. Өөрчлөлт шинэчлэлтийн дараагийн үеийг хэрэгжүүлэх үүднээс бид энэ хоёр байгууллагатай цаашид хамтран ажиллана.

Санхүүжилт нь бэлэн шинэ төслүүдийн тухайд бид зөв зам дээрээ яваа гэж болно. Хувийн хэвшилтэй хамтран санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг баталгаажуулахаар бэлтгэж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлт, инновац, эдийн засгийн бүтээмжид ихээхэн нөлөө үзүүлэх шинэ төслийг эхлүүлнэ. Бид байгаль орчинд ээлтэй халаалт нэвтрүүлэх, хямд өртөгтэй ногоон барилга, шинээр ойжуулах, дахин ойжуулах, нөхөн сэргэдэг хөдөө аж ахуй зэрэг маш олон санаан дээр ажиллаж байна. Эдгээрт “Найрамдал” төслийн санаачилгуудыг багтаах юм.

“Найрамдал” төслийн талаар сурвалжлан, мэдээлэл хүргэж буй Mongolian Economy сэтгүүлд чин сэтгэлээсээ талархахын зэрэгцээ та бүхэнд сайн сайхныг хүсье. “Найрамдал” төсөл, мөн дараа дараагийн өөрчлөлтийг танай сэтгүүл цаашид дэмжин ажиллахыг хүсэж байна. ■

Хамтын ажиллагаа



Дархан-Уул аймаг гадаад хамтын ажиллагаагаараа орон нутагт манлайлж байна

“Найрамдал” төслийн гадаад хамтын ажиллагааг таниулах, тэлэх нэгдүгээр зорилтын хүрээнд 12 удаагийн тэргүүн туршлага солилцох форум болон туршлага

судлах айлчлалыг хийжээ. Мөн солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Туршлага судлах айлчлалын хувьд ганцхан “Тогтвортой, ногоон, жишиг

амины орон сууц” форум дангаар нь буюу ямар нэгэн айлчлалгүйгээр зохион байгуулжээ. Бусад форум давхар айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан байна.

Анхдугаар Тэргүүн туршлага солилцох форум болов

2022.07.01-02

“Найрамдал” төсөл Тэргүүн туршлага солилцох анхдугаар форумдаа 2022 оны долдугаар сарын 1, 2-ны өдрүүдэд Дархан хотод зохион байгуулав. Төслийн нэг хэрэгжүүлэгч тал болох Зүүн Өмнөд Европын Нутгийн Удирдлагын Консорциум (ЗӨЕНУК)-ын зүгээс Европын улсуудын холбогдох төлөөлөгчдийг форумд урьж, оролцуулжээ. Тодруулбал, ЗӨЕНУК-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Келмэнд Заяажигаар удирдуулсан ЗӨЕНУК-ын Хэрэг эрхлэх газрын бусад гишүүд, Хорват улсын Риека хотын захирагч Марко

Филипович, Словени улсын Аядовшина хотын захирагч Таде Беочанин, Словенийн хотын захиргаа, нутгийн холбооны (SOS) Ерөнхий нарийн бичгийн дарга Ясмина Видмар болон Монтенегро улсын Бар хотын захирагч Душан Рейчевич тэргүүтэй эрхмүүд Дархан хотыг зорин ирж, “Найрамдал” төслийн анхны Тэргүүн туршлага солилцох форумд оролцов. Тус форум нь төвлөрлийг сааруулах, бүс нутгийг хөгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөрийг дэмжиж, орон нутгийн эдийн засгийн хөгжил, тогтвортой аялал жуулчлал, хөдөө аж ахуй болон арьс шир, нэхмэл эдлэл, хүнс үйлдвэрлэл болон ЖДҮ-ийн бүтээгдэхүүний сайжруулалтад чиглэсэн бодлого, хэрэгжүүлэлтэд анхаарлаа хандуулжээ. ►

► **“Ухаалаг Ногоон Хот” Тэргүүн туршлага солилцох айлчлал**

2022.10.30-11.12

Дархан-Уул аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар түүний хэлтэс, нэгжийн удирдлагууд, төслийн ажилтнууд, ДЕФ-ын гишүүд, дотоодын бизнес эрхлэгчдийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгч Европт 11 хоногийн айлчлал хийв. Тус томилолт “Ухаалаг ба Ногоон Хот” сэдвийн дор явагдсан бөгөөд 2022 оны аравдугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 12-ны хооронд Турк, Хорват, Словени улсад зочлов. Айлчлалын гол зорилго нь гүйцэтгэх болон салбар хороодын гишүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, төрөл бүрийн сэдвээр тэргүүн туршлагаадаасаа олон, суралцах боломжийг олгох байв.

Европын Холбооны “Тогтвортой хотуудын түншлэл” хөтөлбөрөөс зохион байгуулсан уулзалтад оролцов

2023.03.07-09

Европын Холбооны “Тогтвортой хотуудын түншлэл” хөтөлбөрөөс Бельги улсын Брюссель хотноо зохион байгуулсан дэлхийн анхдугаар уулзалтад Монгол Улсаас “Найрамдал” төслийг хэрэгжүүлэгч Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, төслийн зохицуулагч бөгөөд ЕДИЭТ-ийн захирал П.Мэнд-Амгалан, төслийн удирдах, гүйцэтгэх хорооны гишүүн Камлеш Патак нар оролцлоо. Хотуудын төлөөлөгчид санал солилцох, хэлэлцүүлэг зохион байгуулах, тэргүүн туршлага солилцох, дэлхийн ирээдүйн хот байгуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үр дүнг бүхэлд нь зураглах стратегийн харилцааны арга зам бий болгох талаар гурван өдрийн турш чуулав.

“Маргаашийн хот - Ухаалаг хот Дархан, Тогтвортой ногоон санхүүжилт” туршлага судлах айлчлал

2023.06.26-2023.07.01

“Маргаашийн хот” форум хотууд ухаалгаар хөгжихөд тулгамдаж буй асуудлуудаа ярилцаж, хамтдаа шийдвэрлэж, хамтдаа хөгжихөд чухал ач холбогдолтой болов.

“Маргаашийн хот” хөрөнгө оруулалтын форумаас гарах үр дүн нь Дархан-Уул аймагт хэрэгжих мега төслүүд хэрэгжих суурь нөхцөлүүд бүрдэх юм. Мөн дотоодын хөрөнгө оруулагчид орон нутагт хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулах түншлэлийн



Соча голын хавцал эргийг хэрэн татсан олсон зам (zipline)-аас туршлага судалж буй нь. Бовец хот, Словени улс

гэрээ байгуулагдахаас гадна гадаадын хөрөнгө оруулагчидтай тодорхой чиглэлд хамтран ажиллах санамж бичгүүд зурав.

Нийгмийн тэгш, хүртээмжтэй оролцоо, сайн засаглал, Тогтвортой Хөгжлийн зорилтуудыг нутагшуулах туршлага солилцох уулзалт болов

2023.11.19-22

Монтенегро улс, Бар, Котор, Цетинье, Даниловград хотод сайн засаглал, нийгмийн тэгш хүртээмжийн дор энтрепренершипийг хөгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, төрийн цахим үйлчилгээний дэвшлийн талаар хэлэлцэж цаашид хамтран ажиллах боломжийг судлав.

Дархан-Уул аймаг болон Бар хот нь тогтвортой аялал жуулчлал, зам тээвэр, төрийн байгууллага, хувийн хэвшил, их сургуулиудын хамтын ажиллагаа болон соёл амралт, спорт чиглэлээр хамтарч ажиллах санамж бичиг солилцлоо.

2023.11. 20-25

“Найрамдал” төслийн ээлжит Тэргүүн туршлага солилцох форумыг Монтенегро, Словени улсад зохион байгуулав. Энэ удаагийн тэргүүн туршлага солилцох форум нь нийгмийн тэгш хүртээмжтэй бодлого, сайн засаглал, тогтвортой хөгжлийн зорилтуудыг нутагшуулах арга хэмжээг Дархан-Уул аймагт хэрхэн зохион байгуулж байгаагаа үнэлэх, аймгийн хүүхэд хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээ, жижиг дунд бизнесийг дэмжих бодлогын хүрээнд зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, түүний ололттой болон сул

► талууд, тулгамдаж буй бэрхшээл, даван туулсан арга замын талаар нээлттэй хэлэлцүүлж Европын хотуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ, туршлагатай харилцан танилцаж тэргүүн туршлага хуваалцав.

2023.11.23-25

Словени улс, Аядовшина, Любляна хотод Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд жил бүр орон нутгийн 3-4 төрлийн бүтээгдэхүүний сонгон авч брэнд бүтээх, жижиг, дунд үйлдвэрлэл, гар урлалыг аялал жуулчлал болон томоохон үйлдвэрлэлүүдтэйгээ уялдаатай хөгжүүлэх бодлого, бүс нутгийн аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн платформыг бүтээж үйлдвэрлэлийн болон зах зээлийн тэлэлтийг эрчимжүүлэн ажиллаж буй талаар туршлага судлав.

Дархан-Уул аймаг тус хоттой “Хотуудын түншлэлийн харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгууллаа. Санамж бичгийг байгуулснаар эрчимжсэн газар тариалан, байгаль орчин, хөдөө орон нутгийн хөгжил, инновацын чиглэлээр туршлага солилцох, технологи, дамжуулах, нутагшуулах, зөвлөн туслах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдэж байна.

“Олон улсын түншлэлийн хот, бүс нутгууд: Глобал гарцыг нутагшуулах нь” форум болов

2023.11. 29-12.01

Европын Комиссын Олон Улсын Түншлэлийн Ерөнхий Газар (INTRP) болон Европ Бүсийн Хороо (CoR) хамтран зохион байгуулсан “Олон улсын түншлэлийн хот, бүс нутгууд: Глобал гарцыг (Global Gateway) нутагшуулах нь” форум Бельгийн Брюссель хотод зохион байгуулагдав. Тус форумд Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, "Найрамдал" төслийн удирдагч П.Мэнд-Амгалан, "Найрамдал" төслийн ДЕФ-ын гүйцэтгэх хорооны гишүүн Камлеш Патак нар оролцлоо. Global Gateway нь Европын Холбооноос тодорхой зарчимд тулгуурлан дэлхийн хэмжээнд дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулах, эдийн засгийн түншлэлийг бий болгох стратеги бүхий хөтөлбөр юм.

Тогтвортой хотуудын түншлэл хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймагт “Найрамдал” төсөл хэрэгжиж эхэлснээс хойш Дархан Европын Комиссын түнш хотоор бүртгэгдэж, 2023 онд Уур амьсгалын өөрчлөлт болон эрчим хүчний талаарх Дэлхийн хотуудын захирагч нарын хэлэлцээрт албан ёсоор гишүүнчлэлээр элссэн байна. Энэхүү форумд Ази тивээс Дархан хот, Вьетнам улсын Хюэ хотууд оролцжээ.

2023 оны 12 дугаар сарын 03-09

АНЭУ-ын Дубай хотноо болсон НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын талуудын 28 дахь бага хуралд Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, төслийн удирдагч П.Мэнд-Амгалан, "Найрамдал" төслийн ДЕФ-ын гүйцэтгэх хорооны гишүүн Камлеш Патак нар оролцож, аймаг орон нутаг болон “Найрамдал” төслийн гадаад хамтын ажиллагааг таниулах, харилцааг тэлэх уулзалтуудыг амжилттай хийв.

Ойн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхээр болов

2024.03.01

Европын Холбооны хамтарсан санхүүжилттэй “Найрамдал” төслийн үйл ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, “БиФлат Сервис”, “Грийн Вөркс” зөвлөх үйлчилгээний байгууллага болон Хөдөө Аж Ахуйн Сургуулийн Дархан-Уул аймаг дахь Агроэкологи Бизнесийн Сургуулиуд хамтран Ойн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхээр болжээ. Энэхүү төсөл нь үе шаттайгаар хэрэгжих бөгөөд нэгдүгээр шатанд тус аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол зэрэг сумын нутаг дэвсгэрт дэх 1000 га ойн талбайг сонгох юм байна. Төсөл нь макро эдийн засгийн хүчин зүйл, орон нутгийн дэмжлэг, тариалалтын менежментийг харгалзан зорилтот ойн сан бүхий 10,000 га талбайд хөрөнгө оруулалт хийж, зураг төслийг боловсруулахаар, тохиролцжээ. Уг төслийн эхний нүүрстөрөгчийн нэгж хэлбэрээр гаргах хүртэлх хугацаа нь 15 жил байх аж.



Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, ХААИС-ийн Дархан салбар Агроэкологи Бизнесийн сургууль, “Грийнвөркс Консалтинг” компани, “БиФлат Сервис” компаниуд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах үеэр. 2024.03.01. Дархан хот.



Европын Холбооны гишүүн орнуудын төлөөлөгчид болон "Найрамдал" төслийн баг

► Тогтвортой ногоон, жишиг амины орон сууц форум

2024.04.18

Дархан хотыг “Ухаалаг, ногоон хот” болгох алсын хараа, хотын тогтвортой байдал, амьдрах орчныг сайжруулах үндэсний загвар хот болгох, оролцогч талууд харилцан туршлага солилцох замаар боломжит өртөг бүхий амины орон сууцны цогц шийдэл жишиг гэр хорооллын эко системийг бий болгоход энэхүү форумын зорилго оршино.

Шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн түншлэл форум

2024.05.30

Дархан-Уул аймгийн төдийгүй Төвийн бүсийн хэмжээнд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд төр, хувийн хэвшил, их сургууль, шинжлэх ухааны байгууллагууд нэгдэн хамтын ажиллагаагаа өрнүүлэх, шинэлэг шийдлүүдийг хамтран бүтээх платформыг бий болгох явдал юм. Тус форумд Турк, Монтенегро, Хорват, Грек, Умард Македон, БНХАУ, БНСУ-ын төлөөлөгчид оролцов.

“Төвийн бүсийн хөгжлийн чуулган-Тэсвэртэй хот” шинэ стандарт олон улсын форум

2024.11.28

“Төвийн бүсийн хөгжлийн чуулган-Тэсвэртэй хот” шинэ стандарт олон улсын форум Дархан-Уул аймагт

боллоо. Дархан-Уул аймагт хэрэгжиж буй Европын Холбооны хамтарсан санхүүжилттэй “Найрамдал” төслийн гарааны бизнесийн бойжигч (Үлэмж зөгийн жишиг аж ахуйн төсөл) “Тэс-Оргил” ХХК нь “Найрамдал” төслийн Европын Холбооны Улсуудтай харилцан сайн туршлагаа хуваалцах зорилтын хүрээнд Словени Улсын Любляна хотын зөгийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, Европ Дарханы инновац энтрепренершип төвтэй гурван талт Харилцан ойлголцлын санамж бичгийг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр байгуулав.

“Европ, Монголын хотуудын хамтын ажиллагаа” форум Брюссель хотноо болов

2025.02.17-21

Европын Холбооны хамтарсан санхүүжилттэй “Найрамдал” төслийн ээлжит тэргүүн туршлага солилцох форум “Европ, Монголын хотуудын хамтын ажиллагаа” сэдвээр Бельги Улсын Брюссель хотноо 2025 оны хоёрдугаар сарын 17-21-ний өдрүүдэд болов. Энэхүү айлчлалын зорилго нь хот төлөвлөлт, тэсвэртэй байдал, инновацийн чиглэлээр хамтын ажиллагааг дэмжих замаар Монгол, Европын хотуудын харилцааг бэхжүүлэх явдал юм. Форумд Эрчим хүч, уур амьсгалын асуудлаар нэгдсэн дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээр (GCoM), Хотын шилжилтийн хөтөлбөр (UTM) байгууллагуудын олон улс, бүс нутаг хариуцсан захирлууд оролцож Монгол орны байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн мэдээллийг авлаа.

Европ Монголын ухаалаг хотуудын бизнес түншлэл форум

2025.04.21

Альбасете хот нь Ухаалаг хот болох зорилгоор хэд хэдэн амжилттай төслийг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулж, дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлжээ. Форумгаар Дархан хот дэлхийн ухаалаг хотуудын сайн туршлагаас суралцах, хэрхэн хүн төвтэй ухаалаг, ногоон, хүртээмжтэй хот байх талаар судалж цаашдын орон нутгийн бодлого шийдвэртэй тусгаж болохуйц санаачилгуудыг харсан үр дүнтэй форум болов.

Албаны хүний үг

О.Хүрэлчулуун: “Найрамдал” шиг төсөл Монголд байхгүй

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга О.Хүрэлчулуунтай ярилцлаа.

-Дархан-Уул аймагт Европын Холбооны санхүүжилттэй “Найрамдал” төсөл хэрэгжээд дуусах гэж байна. Энэ төсөлд төрийн зүгээс ямар оролцоотой ажилласан бэ. Төслийн үр өгөөж ямар байсан гэж та харж байна вэ?

-“Найрамдал” төслийг ярихаасаа өмнө хэрэгжих болсноос нь эхлэх нь зөв байх. Манай эрдэмтэн, докторууд аливаад гарц гаргалгаа, төсөл хэрэгжүүлэх боломж байдгийг судлаад орон нутагтаа хамтран ажиллах санал тавьсан. Орон нутгийн удирдлагын зүгээс мэдээж дэмжиж хамтарч ажиллана гэдгээ илэрхийлсэн. Төсөл гурван хэрэгжүүлэгч талтай. Үүний нэг нь Зүүн өмнөд Европын нутгийн удирдлагын консорциумтай төсөл хэрэгжүүлэгчээр хамтран ажиллаад явж байна. Энэхүү төслийн орон нутгийн хүлээх үүрэг гэж бий. Нийт төслийн санхүүжилтийн 5 хувийг гаргаад хамтарч ажиллахаар болсон. Ингээд төсөл маань гурван жил хэрэгжээд өндөрлөх шат руугаа орж байна. Аймаг орон нутагт маш үр өгөөжтэй төсөл болсон. Хамгийн тод жишээ гэвэл, Европын Холбооны гурван улсын хоттой Дархан-Уул аймаг хамтран ажиллах үүд хаалгыг нээж өгч, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулаад байна. Дээр нь төрийн албан хаагчид руу чиглэсэн сургалт хөтөлбөрүүдийг маш амжилттайгаар зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн сургалтын хэрэгцээнд зориулсан хөтөлбөрийг боловсруулсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд эрдэмтэн багш, сургалтын байгууллагуудтай хамтарч ажиллах үе шаттай сургалтуудыг явууллаа. Үндсэндээ 400 гаруй төрийн албан хаагчийг чадавхжуулах, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх зэрэг сургалтыг амжилттай зохион байгуулсан. Мөн төслийн хүрээнд бид сургалтын хөтөлбөртөө “төрийн албан хаагчийн сургалтын танхимтай больё” гэдэг асуудлыг тусгаж өгсөн. Тэгээд сургалтын танхимыг бий болголоо. Зөвхөн сургалт явуулахаас илүүтэйгээр



Төвийн бүсийнхээ Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн Дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээрт элсүүлэх ажил эхлээд явж байна

төрийн албаны шинэтгэлийн хүрээнд 2019 оноос хойш хэрэгжиж байгаа Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс төрийн албанд орох ерөнхий шалгалт, тусгай шалгалтыг зохион байгуулах бүрэн боломжоор хангагдсан.

Мөн “Найрамдал” төсөл 10 гарааны бизнест тус бүрд нь 70 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгийг үзүүлсэн. Үүнийг дагаад тодорхой хэмжээний ажлын байр Дархан-Уул аймагт нэмэгдэж байгаа. Ийм амжилттай хэрэгжсэн төслийн талаар товчхон дурдахад ийм байна. Дурдаад байвал маш олон үйл ажиллагаа байгаа. Жилд дор хаяж гурваас доошгүй удаагийн Европ Монголын хоорондын харилцан туршлага солилцох форумыг зохион байгуулсан. Энэ форумуудад төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд оролцож, хамтын ажиллагааны үүд хаалгануудыг нээж өгсөн. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах туршлага судлах айлчлалуудыг зохион байгуулсан. Европын орнуудын мэргэжил нэгтэй газрууд, жишээлбэл, онцгой байдал, цагдаа, хотын захиргаад, эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэр аж ахуйн нэгж нь хэрхэн ажиллаж байгаа талаар туршлага судлах айлчлал, солилцооны хөтөлбөрүүдийг мөн зохион байгуулсан.

Хэлэлцүүлгүүдээс гарсан санал санаачилгыг ►

► орон нутаг үйл ажиллагаандаа төлөвлөгөөндөө хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг бодлогыг ажил болгоод явж байна. Бойжигч төслүүд дотор хог хаягдлын менежментийг хэрхэн сайжруулах талаар төсөл хэрэгжүүлсэн байх жишээтэй. Утаагүй зуух үйлдвэрлэгчийг дэмжиж ажилласан. Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар төслүүд хэрэгжиж байна.

–“Найрамдал” төсөл олон талын оролцоог хамруулсан, тэдэнд мэдлэг мэдээлэл олгох, цаашлаад Европын хотуудтай хамтрах зэрэг ач холбогдлыг нь тооцвол үр дүнтэй төсөл юм байна. Энэ төслийн хүрээнд цаашид ямар боломжууд нээгдэж байгаа вэ?

–Найрамдал төсөл үндсэн дөрвөн чиглэлтэй олон талт хамтын ажиллагааг дэмжинэ. Төрийн бүтээмжийг сайжруулна. Инновац, технологит суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжих, хог хаягдал, байгаль орчныг доройтлыг бууруулах зэрэг өргөн хүрээнд зохион байгуулагдаж байгаа. Мөн Ухаалаг хотыг дэмжинэ.

Манай Дархан-Уул аймаг Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн Дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээр гээд олон улсын байгууллагад элссэн. Карбон зах зээлд хамтарч ажиллах гэрээ байгуулж байна. Бид энэ ажлын хүрээнд 20 сая мод тарих төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг төслийн онцлог нь нэг байшин барьчихаад зогсдог төсөл биш. Цаашид үргэлжлүүлээд бүхий л боломж бололцоо, гарц гаргалгааг бий болгож байна.

Саяхан гадаад айлчлалыг Европын Холбооны төв Бельгийн Брюссельд зохион байгуулсан. Европын Холбооны төсөл хөтөлбөрүүдийг хариуцаж ажилладаг экспертүүд, мөн хотуудын захирагч нартай уулзалт хийж гарц гаргалгаа, орон нутаг цаашлаад Монгол Улс руугаа хөрөнгө оруулалт татах ямар боломж байгааг судалсан. Санаж сэдэж чадвал олон боломж байгааг тэндээс харлаа. Монгол Улсын Засгийн газраас Бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд бүсийнхээ хоёр аймгийг энэ уулзалтад оролцуулж хамтын ажиллагааг эхлүүлсэн. Төв болон Сэлэнгэ аймгийг Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн Дэлхийн хотуудын дарга нарын хэлэлцээрт элсүүлэх ажил явж байна.

–Дархан Европын Бүс нутгийн форум байгуулсан талаар тодорхой яриад өгөөч. Цаашид энэ форум үргэлжилнэ гэсэн үг үү?

Европын холбооны гурван хоттой аймгийн засаг дарга санамж бичиг зурсан

–Энэ төслийн нэг хэсэг нь форум байгуулсан. Манайх форум гэхээр хурал зөвлөгөөн гэж ойлгодог. Гэтэл энэ форум бол нийгмийн институт юм. Энэ форумын гүйцэтгэх зөвлөлийн даргаар миний бие томилогдоод ажиллаж байгаа.

Төсөл дуусахад энэ форум үргэлжлэх үү, гэдэг шийдэл гараагүй байна. Мэдээж хамтын ажиллагаагаа алдахгүйн тулд зөвхөн энэ төслөөр бүх зүйлээ хаахгүй. Европын Холбоо болон эрдэмтэн докторуудтайгаа цаашид хамтарч ажиллана. Зөвхөн төсөл гэхгүй аймгийн Засаг даргын санаачилгаар төрийн албан хаагчдыг IELTS-ын оноонд тэнцэхүйц чадавхтай болгох үүднээс англи хэлний сургалтад хамруулсан. Тодруулбал, Европын Холбооны донор орнуудаас олж болох ямар боломж байгааг нээх зорилгоор англи хэлний өндөр боловсролтой төрийн албан хаагчийг бэлдэж байна гэсэн үг.

Хэлтэй бол хөлтэй гэдэг чинь энэ юм байна. Манай ХААИС-ийн доктор, профессорууд л энэ төслийг хайж олсон шүү дээ. Европын Холбооны гурван хоттой аймгийн Засаг дарга санамж бичиг зурсан. Энэ санамж бичгүүдийн хүрээнд мэргэжилтэй боловсон хүчин дадлагажуулах, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр хамтарч ажиллах гэсэн үндсэн санаа явж байгаа.

–Дархан-Уул аймагт “Найрамдал” төслийн эдийн засгийн ач холбогдол шууд болон шууд бусаар хэрхэн хэрэгжиж байна вэ?

–Бизнес эрхлэгчдийг хамруулсан форумуудын ач холбогдол нөлөөлөл үзүүлж байна. “Найрамдал” шиг төсөл Монголд байхгүй. Анх удаа Европын Холбооны санхүүжилтийг авч чадсан төсөл юм. Орон нутгийн удирдлагын зүгээс багш нартаа маш их талархаж явдаг. Энэ их цар хүрээтэй амжилттай хэрэгжих төслийг анхнаас нь боловсруулж санаачлаад орон нутагтайгаа хамтарч ажиллана гэдэг бол талархууштай үйл явдал. Үүний үр нөлөөгөөр санаж сэдээгүй хүмүүст санаа өгчихөж байна. Орон нутгийн тодорхой нэгж байгууллагууд санхүүгийн дэмжлэг авах боломжоор хангагдаж байна. Хамгийн гол санхүүжилт туршлага судлах юм. Хүнд “май” гээд бэлэн юм өгөхөөс илүүтэйгээр “та үүнийг хийхийн тулд ийм аргачлал, туршлага, боловсрол эзэмшвэл таны бизнес хөгжинө” гэсэн өгөөжийг өгч байна шүү дээ. Боловсрол мэдлэг олгож, тархи руу нь юм хийсэн, туршлага солилцсон, ихийг мэдүүлсэн төсөл гэж хэлмээр байна. ■

Нөөц боломжийг нээх нь

Дархан-Европын бүс нутгийн форум байгуулагдав



“Найрамдал” төслийн нэгдүгээр зорилт нь, Европ Монголын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх юм. Энэ зорилтын хүрээнд Дархан-Европын бүс нутгийн форум байгуулагдсан бөгөөд нэг удаагийн хурал, зөвлөгөөн бус байгууллагын хэлбэртэй нийгмийн институтын түвшинд үйл ажиллагаа явуулдагаараа онцлогтой. Тодруулбал, Дархан-Европын бүс нутгийн форум (ДЕФ) нь Дархан-Уул аймгийн бүс нутгийн хөгжлийг удирдах, төвлөрлийг сааруулах, бүсчилсэн хөгжил, уялдаа холбоог нэгдсэн бодлогоор хангах зорилготой урт хугацаанд, тогтвортой үйл ажиллагаа явуулах нийгмийн институт юм.

Дархан-Европын бүс нутгийн форум олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Европын түнш байгууллагуудын төлөөлөл, Азийн бүсийн экспертүүд болон Дархан бүс нутгийн төлөөллүүдийг оролцуулжээ. Түүнчлэн таван дэд хороотой бөгөөд Дархан бүс нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг хэлэлцээд Европын сайн туршлагаудаас санаа авч, санхүүжилттэй төслүүдийг босгон хэрэгжүүлэх зорилготой юм.

Дархан-Европын бүс нутгийн форумын зорилт:

1. Хотын засаглалыг бэхжүүлэх, тогтвортой байдал, ногоон байгууламжийг бий болгох, инновац, бизнес эрхлэлтийг дэмжих замаар эдийн засгийн

Дархан-Европын бүс нутгийн форум олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Европын түнш байгууллагуудын төлөөлөл, Азийн бүсийн экспертүүд болон Дархан бүс нутгийн төлөөллүүдийг оролцуулжээ

хөгжил цэцэглэлтийг сайжруулах, нийгмийн оролцоог хангах, тэргүүлэх чиглэлүүдэд боломжуудыг бий болгох.

2. Монгол Улсад бүс нутгийн хөгжлийн бодлогыг үр дүнтэйгээр нэвтрүүлэхийн тулд Дархан-Уул аймаг болон Европын Холбооны бодлого боловсруулагчдын хооронд бүс нутгийн туршлага солилцох боломж олгоно. ДЕФ нь Дархан-Уул аймгийн төрийн байгууллагууд болон бусад байгууллагуудад мэдлэг солилцох, туршлага дамжуулах, иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмжийг тэлэх зэрэг бодлогыг үр дүнтэйгээр нэвтрүүлэх замаар бүс нутгийн хөгжлийн бодлогыг тэлэх.
3. Дархан-Уул аймгийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн чадавхыг бэхжүүлэх, бусад орны авч хэрэгжүүлдэг бодлогод суралцах замаар үндэстэн дамнасан хамтын ажиллагааг бий болгож, төсөл боловсруулах түүгээр дамжих хамтын ажиллагаа зэргээр тогтвортой хотын хөгжлийн үүрэг амлалтад хүрч болохуйц гарч гаргалгаа зураглах, бие биеийнхээ бодит туршлагаас суралцах нь мөн төрийн байгууллагуудын хамгийн бага нэгжээс шийдвэр гаргах эрх мэдлийг бэхжүүлэх нь энэ үйл ажиллагааны гол цөм нь юм.
4. Дархан-Уул аймгийг эко аж үйлдвэржсэн хот болгохын тулд бизнес эрхлэгчид, эдийн засгийн оролцогч талууд болон байгууллагуудын зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн сэргэлт хийх нэгдсэн платформоор хангах, үйл ажиллагааг дэмжих.
5. Дархан-Европ хөрөнгө оруулалт, төсөл бэлтгэх нэгж нь Кластер хамтын ажиллагаа, түншээ олох, “Дарханд үйлдвэрлэв”, “Дарханд хөрөнгө оруулах” зэрэг хөтөлбөрийг дэмжих, сурталчлах.
6. Ногоон хэлэлцээр, шилжилт зэрэг Европын Холбооны үзэл баримтлалд нийцүүлэн ЕХ болон Дархан-Уул аймгийн хамтын ажиллагааны төслүүдийг хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөртэй, ХОТ-ХОТ, БҮС-БҮС хоорондын хамтын ажиллагаагаар тэдгээрийн бодлогыг судлах орон зайг бий болгох эхлэлийн суурийг тавих. ▶

► **ДЕФ-ын хамтын ажиллагааны уулзалт-1**

Хорват Улс. Риека хот. 2022.11.04

Дархан Европын Форум (ДЕФ)-ын гүйцэтгэх хорооны анхдугаар хурал Хорват улсын Риека хотноо 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр болов. Төслийн хүрээнд зохион байгуулагдах хамтын ажиллагааны уулзалтууд нь инновац, ногоон хот, бизнес эрхлэлтийг дэмжих, тогтвортой, тэгш хүртээмжтэй, шинэлэг өсөлтийг хангахаар гарааны бизнесийг хурдасгах зэрэг сэдвийг чухалчлан авч үздэг.

ДЕФ-ын хамтын ажиллагааны уулзалт-2

Монгол Улс. Дархан-Уул аймаг. 2023.06.21

ДЕФ-ын гүйцэтгэх хорооны хоёрдугаар уулзалт 2023 оны зургадугаар сарын 21-нд “Ухаалаг хот” сэдвийн хүрээнд Дархан хотноо болов. Тус форумас ажлын хэсэг байгуулах, олон улсын төсөл хөтөлбөрөөс засаглал, стратеги, хэрэгжилт, санхүүгийн дэмжлэг авах боломжийг эрэлхийлэв. Мөн “Найрамдал” төслөөр дамжуулан солилцооны хөтөлбөр, Ухаалаг хотын модулийн сургалт, туршилтын төсөлд Дархан хот хамрагдах талаар хэлэлцэж шийдвэрлэв.

ДЕФ-ын хамтын ажиллагааны уулзалт-3

Турк Улс. Истанбул хот. 2023.10.06

Дархан Европын бүс нутгийн форумын гүйцэтгэх хорооны гурав дахь удаагийн хурал 2023 оны аравдугаар сарын 6-нд Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Истанбул Конгресс төвд “Уур амьсгалд ээлтэй, байгалийн гамшигт тэсвэртэй, тогтвортой хотыг бий болгох” сэдвийн дор танхим болон цахимаар хослон амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хуралд Дархан-Уул аймгийн ИТХ-ын төлөөлөл, аймгийн онцгой байдлын комиссын гишүүд, ЗӨЕНУК-ын төлөөлөл болон ДЕФ-ын гүйцэтгэх хороо болон таван салбар хорооны гишүүд оролцов.

Энэхүү хурлаар байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн бэлэн байдал, эрт илрүүлэх болон сэрэмжлүүлэх тал дээр Турк Улс болон Монгол Улс, Дархан-Уул аймгийн хэмжээнд цаашдын хамтын ажиллагаа болон туршлага судлах талаар хэлэлцэв.



ДЕФ-ын хамтын ажиллагааны уулзалт-4

Словени Улс. Любляна хот. 2023.11.25

Дархан Европын бүс нутгийн форумын гүйцэтгэх хорооны дөрөв дэх уулзалт, хурал 2023 оны 11 дүгээр

сарын 25-нд Бүгд Найрамдах Словени Улсын Любляна хотод “Тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулах, нийгмийн тэгш хүртээмжтэй байдал болон сайн засаглал” сэдвийн дор танхим болон цахимаар хослон амжилттай зохион байгууллаа.

ДЕФ-ын хамтын ажиллагааны уулзалт-5

Монгол Улс. Дархан-Уул аймаг. 2024.05.29

Дархан Европын бүс нутгийн форумын гүйцэтгэх хорооны тав дахь удаагийн хурал Дархан-Уул аймагт “Шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн түншлэл” сэдвийн дор танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдлаа.

Зочин илтгэгчид болох Удирдлагын Академийн багш, Дэд профессор С.Галбадрах “Аж үйлдвэр, технологийн парк байгуулах үндэслэл, судалгаа” сэдвээр илтгэл тавьсан бол ЗӨЕНУК-ын Хөтөлбөрийн мэргэжилтэн Боран Иваноски “Нийгмийн эв нэгдэлд хувь нэмэр оруулах Тогтвортой ухаалаг хотууд” сэдвүүдийг онцлон, илтгэлээ тавилаа.

ДЕФ-ын хамтын ажиллагааны уулзалт-6

Бельги Улс. Брюссель хот. 2025.02.17

Дархан Европын бүс нутгийн Форумын хамтын ажиллагааны зургаа дахь удаагийн уулзалт Бельги Улсын Брюссель хотноо 2025 оны хоёрдугаар сарын 17-нд болов. Уулзалтаар “Найрамдал” төслийн өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн ажлууд, ололт, амжилт, гарсан үр дүнг дурдан хэлэлцэхийн зэрэгцээ, Европын орон нутгийн засаг захиргаад холбоо, санаачилгуудын бүтэц зохион байгуулалт, хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрийн талаар ярилцав. ■

Төрийн албан хаагч

“Онц сурлагатан”



"Найрамдал"
төсөл маш
их үр дүнгээ
өгсөн

Дархан-Уул аймаг Монгол Улсын маргаашийн ухаалаг хот болох ирээдүй цухалзаж байна. Учир юундвэ гэвэл хүмүүс нь амар тайван, уур амьсгал, ус нь эрүүлээс гадна Улаанбаатарт байдаггүй олон шинэлэг зүйл байна. Тус аймагт Европын Холбооны санхүүжилтийг Ази тивээс анх удаа авсан “Найрамдал” төсөл хэрэгжиж байна. Төсөл гэхээр л хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нь сонирхож байв. Харин газар дээр нь очоод төслийнхөн бизнес эрхлэгч, орон нутгийн удирдлагуудтай уулзаад төсөөлөл маань эсрэг зүгт чиглэсэн юм.

Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн эрдэмтэн багш, доктор П.Мэнд-Амгалан “Төсөл хэрэгжсэнээр олон хүний аливаад хандах хандлагыг өөрчилж байгаа. Төслийг анхнаас нь унага шиг дагасан “Онц сурлагатан”-ууд олон бий. Тэдний нэг нь Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа юм. “Төсөл хэрэгжихээс өмнө ярьж байсан зүйлүүдээсээ ичдэг. Одоо бол нүд нээгдсэн” гэж ярьдаг юм. Та бүхэн ажлын байр дээр нь очоод үзээрэй. Их шинэлэг байдлаар ажлаа явуулдаг” хэмээн түүний талаар бахархаж ярив. Тиймээс манай сурвалжлагын баг түүнийг өглөө

эрт зорин очлоо. Гаднаасаа эртний захиргааны байр хэр нь үүдээр нь ормогц орчин үеийн хэв маяг нүднээ тусав. Ханандаа усан оргилууртай, ширээ сандлаас эхлээд заалны зохион байгуулалт нь хүртэл сүүлийн үеийн хэв маягтай байлаа. Хамгийн гайхмаар нь байгууллагын 00-ын өрөө нь ухаалаг суултуураас гадна үсчинд орж буй мэт үс угаадаг сандал, гоо сайхны ширээ, эмийн сан зэрэг хүнд хэрэгцээтэй бүх зүйл өрөөтэй харагдана. Тийм 00-ын өрөөг аль ч албан байгууллагаас өнөөг хүртэл хараагүй. Мөн хүүхдийн өрөөтэй. Ер нь л ажилтнууддаа ээлтэй эко ажлын байрыг бий болгожээ.

Ийнхүү Т.Тулгаа дарга болзсон цагтаа ирснээр бидний яриа эхлэв. Тэрбээр мэргэжлийн зураач бөгөөд сүүлд төрийн захиргааны удирдлагаар магистр хамгаалж, төрийн ажилд чармайн ажиллах болжээ. Дөнгөж 40 гарч буй залуухан дарга “Хийж байгаа ажлаа албан тушаал гэж бодохоосоо илүү ажил хийх боломж гэж хардаг. Тиймээс хичээж, суралцаж байна. Өнгөрсөн хугацаанд ард түмний итгэл дэмжлэгээр ИТХ-ын даргаар ажилласан. Дархан сумынхаа Засаг даргаар хоёр дахь удаагаа ажиллаж байна” хэмээн өөрийгөө танилцуулав.

Таны ажил болоод төрийн албанд “Найрамдал” төсөл ямар нөлөө үзүүлсэн бэ, гэсэн асуултад тэрбээр “Дэлхийн зах зээл дээрээс хөрөнгө оруулалт татах, мэдлэг авах, хуваалцах, суралцах томоохон хэмжээний холбоонуудыг тогтоох боломж байна гэдэг санал санаачилгыг манай ХААИС-ийн П.Мэнд-Амгалан доктор анхлан тавьж гадна дотнын консалтингуудтай хамтраад энэ төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Европын Холбооны гурван шатны шалгаруулалтад тэнцэж 2022 оны хоёрдугаар сараас эхэлж “Найрамдал” төсөл Дархан хотод албан ёсоор хэрэгжиж эхэлсэн түүхтэй.

Төслийн нэгжийн даргаар намайг томилсон. Уг төслийн төр талаас гол удирдлагаар нь ажиллаж байна. Төсөл маш их үр дүнгээ өгсөн гэж бодож байгаа. НҮБ-т бүртгэлтэй улс болгон дэлхийн тогтвортой хотуудын 17 зорилтыг хэрэгжүүлэх ▶

► үүргийг хүлээж байгаа. Монгол Улсын аж үйлдвэр дээр суурилсан залуу хотын хувьд манай хот бас үүрэг хүлээсэн. Энэ нь дэлхийн тогтвортой хотуудыг бэхжүүлэхэд Дархан хотод хурдасгуур төсөл болсон.

Миний хувьд, удирдах захирлын хувьд харьцуулж харах, хотын хөгжлийн бодлогыг яаж хийх ёстой юм бэ гэдэг дээр нүд нээгдэж байгаа. Энэ төслөөс магадгүй хамгийн сайн суралцсан хүн би байх. Ямар нэгэн зүйлийг бүтээж ажил болгохын төлөө би энд сууж байгаа. Хотуудын засаглалын тогтолцоог Дархан хотдоо нэвтрүүлэхийг зорьж байна. Нөгөө талдаа уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулж маш тодорхой бодитой ажлууд хийж болох юм байна гэдэг өнцгийг ойлгож мэдэрсэн. Энэ утгаараа Дархан хот уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хотуудын холбоонд нэгдээд байна.

Гадаадын улс орнуудад хоёр засаглалын систем харагдаж байсан. Нэг дэх нь, төр засаг, хоёр дахь нь хотууд сайн дураараа нэгдэж байгаа нь бидний хийх гээд хайж байсан зүйлүүдийн нэг байсан. Өөрсдийнхөө ижил төстэй хотуудаас туршлага судлаад явах нь хамгийн чухал. Яаж хийх вэ гэдэг тал дээр нь сүүлийн хоёр жилийн хугацаанд идэвхтэй ажилласны үр дүнд Дархан хотдоо Монголын Үндэсний хотуудын удирдлагуудын нэгдсэн холбоог байгуулсан. Үүнд 10 мянгаас дээш хүн амтай бүх суурин газруудыг нэгтгэхийн төлөө зорьж байна. 2024 онд Төрийн бус байгууллагаа улсын бүртгэлд бүртгүүлсэн. Одоо дүрмийн болон үйл ажиллагааны шинэтгэлийг хийхээр ажиллаж байна” гэж ярьсан юм.

Дархан сумын Засаг дарга Т.Тулгаагийн мөрөөдөл нь "Дархан хот хагас сая хүн амтай, эдийн засаг нь солонгорсон, эко энтертайнмент, смарт зэрэг хэв шинжийг агуулсан хот төлөвлөлт нь зөв, хүмүүс нь сэтгэл хангалуун, ажилтай орлоготой, аз жаргалын индексээрээ Азид үнэлэгддэг гоё хот байгаасай" гэж хүсдэг гэнэ. Тэрбээр “Би ирээдүйдээ итгэлтэй байдаг. Дархан сумын Засаг даргын Тамгын газрынхаа баг хамт олноор бахархдаг. Хамгийн ахмад настай нь би. Дандаа 1990-2000 оны залуучууд ажилладаг. Энэ залуучуудтайгаа зэрэг өсөж байна даа. Залуусаасаа суралцдаг. Ажиллахад урам зориг эрч хүч өгдөг. Айдсаар биш, ойлголцож удирдахыг чин сэтгэлээсээ хичээж байгаа. Гадаадад суралцаад

ирсэн мундаг залуус олон бий. Тэдгээр залуусын бүтээмж үнэхээр өндөр. Ирээдүйдээ итгэх ёстой. Гоё цаг хугацаа ирж байна. Залуучуудаа ажлаас халшрах биш урам зоригтой, санаачилгатай, бүтээмжтэй ажлуулахын тулд бүх хүчээ дайчилж байгаа. Аливааг шинээр сэтгэж, бусдадаа бас хуваалцахыг хүсэж байна” гэсэн юм.


Дархан сумын Засаг даргын Тамгын газар олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Дархан сумдаа анх удаа ахмад настны хөдөлмөрийн бирж байгуулж, 126 ахмад настныг хөдөлмөрийн зах зээл дээр гаргажээ. Мөн хүүхэд хөгжил рүү чиглэсэн “Амин зүрх” төсөл эхлүүлсэн байна. Түүнчлэн Дархан хотын соёл амралт тохижилт үйлчилгээний хог тээвэрлэлтийн газруудыг байгуулсан бөгөөд төрөөс татаас авалгүй бие даасан хувилбар руу шилжүүлэх том менежментийг хийж байгаа гэнэ. Дархан сум Монгол Улсад цор ганц төрийн албаны ERP систем нэвтрүүлжээ. Энэ мэтчилэн олон ажил буй бөгөөд жижиг гэлтгүй сайн туршлага Дархан суманд байна. ■

"Найрамдал" төсөл дэлхийн тогтвортой хотуудыг бэхжүүлэхэд Дархан хотод хурдасгуур болсон



Иргэдийн оролцоот засаглал

Маргаашийн хот



“Найрамдал” төслийн хоёрдугаар зорилт нь иргэдийн оролцоот засаглалыг дэмжих юм. Энэ зорилтын хүрээнд Дархан форумыг байгуулжээ. Өндөр хөгжилтэй орны хотууд дэргэдээ форумтай байдаг төдийгүй шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, судлаач, иргэний нийгмийн байгууллага, иргэн гээд бүх талыг оролцуулж, тулгамдаж буй асуудлаа хэлэлцдэг. Ийнхүү төвлөрч ярилцаад зөв гарц гаргалгаа, шийдэл гаргаад тэрийгээ орон нутгийн бодлогод тусган хэрэгжүүлдэг байна. Энэ бол шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах сонгодог загвар гэдгийг П.Мэнд-Амгалан доктор онцолсон юм. Дархан форум байгуулагдсанаар дээрх соёлыг орон нутагт төлөвшүүлэх зорилгоор 10 форум зохион байгуулжээ.

Мөн төрийн албан хаагчдыг чадавхжуулах ажлууд хийгдсэн байна. НҮБ-аас тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн алба ямар

**10 модуль
бүхий сургалт
зохион
байгуулсан**

хандлагатай байх, ур чадвар, бодлогын хувьд хэрхэн төлөвшсөн байх вэ гэдэг чиглэлээр төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага байдаг бөгөөд үүнийг орчуулж, монгол хөрсөн дээр буулгаад 10 модультай том сургалтын хөтөлбөр боловсруулжээ. Энэ 10 модулиараа 400 гаруй төрийн албан хаагчдад сургалт явуулаад байгаа юм байна. Мөн энэ зорилтын хүрээнд Ухаалаг хотын концепцийг боловсруулж, эмнэлгийн анхан шатны үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох, ИТ технологийг нэвтрүүлэх зорилгоор өрхийн эмнэлгүүд, нэгдсэн эмнэлэгт “E-Health” системтэй холбох гэх мэт төслүүдийг амжилттай хэрэгжүүлжээ.

Ухаалаг хот бол бүх талаараа ухаалаг байх ёстой. Ядаж л утаагүй байх ёстой, замын гарц тэмдэглэгээ нь тодорхой, ногоон байх ёстой гэдгээс бүх зүйл эхэлнэ. Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа “Миний хувьд харьцуулж харах, хотын хөгжлийн бодлогыг ▶

► яаж хийх ёстой юм бэ гэдэг дээр нүд нээгдэж байгаа. Хотуудын засаглалын тогтолцоог Дархан хотдоо нэвтрүүлэхээр зорьж байна. Нөгөө талдаа уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулж маш тодорхой бодитой ажлууд хийж болох юм байна гэдэг өнцгийг ойлгож мэдэрсэн. Энэ утгаараа Дархан хот Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хотуудын холбоонд нэгдээд байна.

"ДАРХАН ФОРУМ"-ЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТУУД

“Хоггүй Дарханыг хамтдаа бүтээе”



Найрамдал төслийн хүрээнд 2023 оны хоёрдугаар сарын 15-ны өдөр Дархан-Уул аймагт “Хоггүй Дарханыг хамтдаа бүтээе” сэдвээр Дархан Форумын анхдугаар чуулга уулзалтыг зохион байгуулав. Бодлого боловсруулагч, мэргэжилтэн, судлаач, мэргэжлийн байгууллагын төлөөлөгчид, үйлдвэр үйлчилгээний салбарын төлөөлөл, ТББ, ИНБ, залуучууд, ахмадууд зэрэг 100 гаруй хүн оролцлоо.

“Хоггүй Дарханыг хамтдаа бүтээе” форумаар Дархан-Уул аймагт зориулсан хог хаягдлын талаар мөрдөх журам болон үйл ажиллагааг нэвтрүүлэх зорилготой байв.

Форумаас гарсан бодит үр дүн нь аймгийн Засаг Даргын дэргэдэх орон тооны бус Хог хаягдлын ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэхүү ажлын хэсэг нь Дархан хотын хогны журмыг боловсруулах юм.

“Үе тэнгийнхний эрүүл харилцаа-эерэг орчин”

“Үе тэнгийнхний эрүүл харилцаа-эерэг орчин” уриан дор Дархан форумын хоёрдугаар уулзалт 2023 оны тавдугаар сарын 4-ний өдөр болов. Үүнд Дархан-



Уул аймгийн Засаг дарга, бодлого боловсруулагчид, мэргэжлийн байгууллага, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, эцэг эх, сурагчид болон ТББ-ын төлөөлөл бүхий нийт 180 гаруй төлөөлөл оролцлоо.

Хүүхдүүдийн төлөөллүүд өөрсдийн үзэл бодол, хэлэлцүүлэг, санаа бодлоор дамжуулан сургуулийн эрүүл орчин, харилцаа холбоог бий болгохыг зорьж байлаа. Тэд Дархан-Уул аймагт сургуулийн орчинд дээрэлхэл, үл тоомсорлох, ялгаварлан гадуурхах явдал хэрхэн өрнөдөг талаар танилцуулав.

Хэлэлцүүлгийн үеэр Дархан-Уул аймгийн Засаг дарга чуулга уулзалтад оролцсон хүүхдүүдийн илгээсэн захидлыг нэг бүрчлэн уншиж танилцсаны эцэст хүүхдүүдийн дунд тулгамдсан, эрсдэл дагуулсан асуудал болоод байгаа электрон тамхийг хязгаарлах шийдвэр гаргасан юм.

“Орон нутгийн төсөв ба иргэдийн оролцоо”



Форумын ээлжит уулзалтыг 2023 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр зохион байгуулж, Орон нутгийн төсөвт санал авах, батлах, хуваарилах, хянах үе шатуудад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэх талаар хэлэлцлээ. Дархан форумд шийдвэр гаргах ►

► түвшний удирдлагууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүд нийт 90 орчим хүн оролцож санал хүсэлтээ нээлттэй илэрхийллээ. Энэ нь орон нутгийн төсвийг төлөвлөхөд иргэдийн оролцоог хангах анхны форум байв.

"Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдаж буй асуудлууд-шийдэл"



"Тогтвортой хөгжлийн зорилго 3-эрүүл мэнд 2030"-д "Хүн бүрд эрүүл мэндийн үйлчилгээ, түүний дотор санхүүгийн эрсдэлийн хамгаалалт, нэн шаардлагатай чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, аюулгүй, үр дүнтэй, чанартай, боломжийн үнэтэй нэн шаардлагатай эм, вакциныг хүртээмжтэй хүргэх" зорилт бий. Үүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох,

"Дархан Форум"-ын үйл ажиллагаанд оролцох иргэдийн дуу хоолой, хувь нэмрийг ханган ажиллах, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, тулгамдаж буй асуудлаар хамтын шийдэлд хүрэх зорилготой "Тулгамдаж буй асуудал-шийдэл" сэдэвт форумыг 2024 оны нэгдүгээр сарын 16-нд 180 орчим оролцогчтойгоор зохион байгуулав.

Иргэдээс форумын сэдвийн хүрээнд хүлээн авсан санал зөвлөмжийг таван багц асуудалд хувааж дүгнэн хэлэлцэж, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхтэй холбогдон гарах зөвлөмжүүдийг боловсруулах, мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн ажиллав.

"Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа-хүнс үйлдвэрлэл эрхлэгчдийн нэтворкинг" форум



2024 оны нэгдүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан тус уулзалтаар Дархан Уул аймагт хүнсний үйлдвэрлэл эрхлэгч иргэн аж ахуй нэгжүүдэд зориулсан сургалт мэдээллийг өгч, үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа үүсгэх боломжийг олгосон нэтворкинг уулзалт хийсэн бөгөөд бүтээгдэхүүн танилцуулах үзэсгэлэн гаргав.

Уг форумын үр дүнг 2024 оны 12 дугаар сард мөн дүгнэж орон нутгийн үйлдвэрлэгчийг дэмжин Дархан хотод үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг худалдан авсан ААН, байгууллагуудыг худалдан авалтын дүнгээр нь шалгаруулан МҮХАҮТ-ын ТОП энтрепренер шагналаар шагнаж алдаршуулав.

"Дархан-Уул аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын өнөөгийн байдал-тулгамдаж буй асуудлууд" форум



2024 оны гуравдугаар сарын 11-нд Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтарч "Дархан-Уул аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын өнөөгийн байдал-тулгамдаж буй асуудлууд" сэдэвт форумыг зохион байгуулав. Боловсролын байгууллага төр дундаа сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ямар асуудал бэрхшээл тулгарч байгаа талаар бодлого тодорхойлогчид, ►

► эцэг эх, боловсролын байгууллагын багш сурган хүмүүжүүлэгч зэрэг бүхий л талын оролцогчдийг хамруулсан. Цаашид хэрхэн асуудлыг шийдвэрлэх боломжуудыг эрэлхийлэн олон талын оролцогчдын байр суурийг авч үзэн форумын санал, дүгнэлт, зөвлөмжийг Дархан-Уул аймгийн ИТХ-д хүргүүлэв.

“Хамтдаа хөгжье” форум



Төслийн зорилт хоёр болох иргэдийн оролцоот засаглалыг бэхжүүлэх ажлын хүрээнд Дархан Форумын “Хамтдаа Хөгжье” сэдэвт уулзалт 2024 оны аравдугаар сарын 30-нд зохион байгуулагдлаа.

Энэ удаагийн Дархан Форумын уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулахад тулгамдаж буй асуудлуудыг бодитоор үнэлж, дүгнэлээ.

“Жарны түүх зууны эхлэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо” форум



“Дархан Форум”-ын үйл ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолой, хувь нэмрийг ханган ажиллах, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, тулгамдаж буй асуудлаар хамтын шийдэлд хүрэх, параолимпын спортын төрлүүдийг сурталчлах, Монгол Улсаа төлөөлөн олон улсын тэмцээнд оролцох тамирчдыг нээн илрүүлэхэд туслахаар Жарны түүх зууны

эхлэл “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо” сэдэвт форумыг 2024 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр зохион байгуулав.

Хүн бүрийг нийтийн биеийн тамираар тэгш хүртээмжтэйгээр хичээллэх сэдлийг төрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэлзүйн эрүүл мэндийг бэлдэх, эрүүл мэнд дасгал хөдөлгөөний мэдлэг мэдээллийг түгээх, хүртээмжийг сайжруулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхтэй холбогдон гарах саналыг мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэх, бодлогын түвшинд нөлөөлөх нь энэ форумын зорилго байв.

Форумын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг дэмжин ажиллах тал дээр аймаг орон нутгийн удирдлагагуудад санал хүргүүлж, төрлийн тоог нэмэгдүүлэх, шигшээ багийг орон нутагтаа барьж, шилдэг тамирчдыг дэмжин ажиллахаар боллоо.

“Эерэг тусгал” форум



Найрамдал төслийн зорилт II болох иргэдийн оролцоот засаглалын хүрээнд ес дэх удаагийн Дархан Форум “Эерэг тусгал” сэдвээр 2025 оны дөрөвдүгээр сарын 8-нд зохион байгуулагдав.

Хэлэлцүүлэгт нийт 168 оролцогч оролцсоноос 157 нь эмэгтэй, 110 нь 35 хүртэлх насны залуучууд байв. Энэхүү форумын зорилго нь нийгмийн сэтгэл зүй болон сэтгэцийн эрүүл мэндэд тулгамдсан асуудлуудад анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажилтан, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжилтэн тэдгээрийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, уялдаа холбоог сайжруулах юм.

Форумын үр дүнд сэтгэл зүйчдийн нэгдсэн холбоо байгуулах, Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал цаашид Дархан форумын үйл ажиллагааг хариуцан ажиллахаар тус тус шийдвэрлэлээ.

Шигтгээ үг

“Найрамдал” төслийн зохион байгуулсан тэргүүн туршлага солилцох форумын оролцогч, илтгэгчдийн онцлох ишлэлээс хүргэе.

Л.Болд:

Монгол Улсаас Бельгийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд



Дархан-Уул аймгийн хэрэгжүүлж буй Найрамдал төсөл нь 35 жилийн түүхтэй Монгол Европын харилцаанд онцгой ач холбогдолтой төсөл юм. Энэ төсөл ингээд хэрэгжээд дуусаж байгаа биш, төслийн үр дүнд жинхэнэ бодитой хамтын ажиллагаа, бодит хөрөнгө оруулалт, хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжих сайхан нөхцөл бүрдэж байгаа юм. Үүнд Элчин сайдын яамны зүгээс зүйл бүрээр тусалж, бүх талаар дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлж байна.

Душан Рейчевич:

ЗӨЕНУК-ын Ерөнхийлөгч, Монтенегро Улс, Бар хотын Захирагч



Европын Холбооны хамтарсан санхүүжилттэй Найрамдал төсөл эхэлсэн цагаасаа Дархан Европыг холбосон гүүр болж харилцан туршлага солилцох, бие биеэсээ суралцахад олон талт үйл ажиллагаа зохион байгуулж ирснийг онцолмоор байна. Мөн Найрамдал төслийн үйл ажиллагааны үр шимд орон нутгийн өөрөө удирдах түвшний албан хаагчид чадавхжиж, нэлээдгүй өөрчлөлт гарсан нь харагдаж байна. Цаашдаа Зүүн өмнөд Европын Нутгийн Удирдлагын консорциум нь Найрамдал төсөл, Дархан-Уул аймагтай хамтран ажиллах бүрэн боломжтой гэдгээ илэрхийлмээр байна.

Пьер Роберто Ремитти:

Уур амьсгал, эрчим хүчний асуудлаар нэгдсэн дэлхийн хотын дарга нарын хэлэлцээрийн Гүйцэтгэх Захирал



Өнөөдрийн бодит жишээнээс дурдвал уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авахад одоо байгаа санхүүжилт хүрэхгүй байх, нэмэлт санхүүжилт босгох шаардлага гарж байна. Үүнийг хамтын ажиллагаа, олны зүтгэлээр шийдэх мэдээж бүрэн боломжтой. Харин энэ боломжийг Найрамдал төсөл маш сайн дэмжиж, гүүр болж холбож байгааг харахад таатай байна.

Өдөр бүр нэмэгдэж байгаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах арга хэмжээний хамгийн эхний бөгөөд чухал алхам бол иргэн бүрийг мэдлэг, мэдээллээр хангах, чадавхжуулах явдал юм. Иймээс ч бид Дархан хот болон Монгол Улсын бусад хот сууринтай уур амьсгалын чиглэлээр хамтран ажиллахад үргэлж бэлэн байх болно.

Б.Урьболд:

БШУЯ-ны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга



Дархан-Уул аймаг стартап экосистемаа хөгжүүлж, цэвэр технологи дээр суурилсан залуусын ногоон хот болох боломжтой харагдаж байна.

Ч.Ундрам:

Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга



Европын Холбооны хувьд, улс орон, бүс нутгуудынх нь хөгжил орон нутгийн чадавхаар тодорхойлогддог гэж үздэг юм байна. Тийм учраас Монгол Улсын хувьд илүү орон нутаг руугаа анхаарч, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжиж ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Б.Жавхлан: Монгол Улсын Сангийн сайд



Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа Найрамдал төсөл бол Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим аймаг төсөлтэй яв цав уялдаж байгаа. Найрамдал төсөл нь Дархан-Уул аймгийн бизнесийн орчны өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, бизнесээ тэлэх боломжийг нээж өгөх чухал ач холбогдолтой, онцлог төсөл юм.

Б.Азжаргал: Дархан-Уул аймгийн Засаг дарга, "Найрамдал" төслийн Удирдах хорооны дарга



Дархан-Уул аймаг зөвхөн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр гээд өөрсдийнхөө ярьдаг зүйлийг биш, дэлхийтэй хөл нийлүүлж, дэлхийн хотуудтай адилхан үүрэг хүлээж, хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдэд оролцож, адилхан хөгжихийн төлөө хичээн, чармайн ажиллаж байгаагаараа Найрамдал төсөл маань онцлог юмаа.

Тапан Мишра:

НҮБ-ын Суурин зохицуулагч



Би Монголд Нэгдсэн Үндэсний байгууллагын суурин төлөөлөгч байх хугацаандаа “Монгол Улс хаана ч, хэзээ ч, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын дор тогтвортой хөгжлийн зорилго ярих цаг дууссан, одоо биелүүлэхийн тулд иргэн бүр ямар нэгэн үйлдэл хиймээр байна” гэж хэлэх дуртай болж байгаа. Яагаад гэвэл бид Монгол Улс 2050 он хүртэл ингэнэ, тэгнэ гэсэн амлалтаа аль хэдийн тодорхойлчихсон, ярьчихсан шүү дээ, одоо хиймээр байна. Тэгэхээр нийгмийн бүхий л талуудын оролцоог тэгш, хүртээмжтэйгээр хангаж, бүгдээрээ энэ зорилтынхоо төлөө хамтдаа зүтгэмээр байна аа.

Д.Эрдэнэбаяр:

Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал



Хөрөнгө оруулалт хийхэд хамгийн өндөр шалгууруудыг бүгдийг нь хангаж байгаа нь Дархан-Уул аймаг юм.

Европ Дарханы Инновац Энтрепренершип Төвийн бүтэц, зохион байгуулалт



П.МЭНД-АМГАЛАН (Ph.D)
Төслийн удирдагч,
ЕДИЭТ-ийн захирал



П.ГАНХУЯГ (Ph.D.)
Энтрепренершип зохицуулагч



Д.ГАНЗУЛ
Оффис менежер



В.ГАНТУЛГА
Гарааны бизнесийн
зохицуулагч



Е.БАТБОЛОР
Бизнес хөгжлийн
мэргэжилтэн



Н.ЭНХХҮСЛЭН
Баримт бичгийн
мэргэжилтэн



П.ЭНХЖАРГАЛ
Төслийн туслах
ажилтан

Инновац

Европ-Дарханы Инновац Энтрепренершип төв шилдэг 10 гарааны бизнесийг бойжуулж байна

“Найрамдал” төслийн гуравдугаар зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй, ногоон, тогтвортой хөгжлийн бодлого бүхий өрсөлдөхүйц гарааны бизнесийг хөгжүүлэх зорилгоор ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн дэргэд Европ-Дархан Инновац Энтрепренершип Төв (ЕДИЭТ)-ийг байгуулжээ. Тус төв нь бизнес ялгарал, шинэ санаа, бойжуулалт, хурдасгуур, гарааны хөрөнгө оруулалтын талаарх сургалт, чадавхжуулах хөтөлбөрөөр дамжуулан бүс нутагт энтрепренершип инновацийн шинэ соёл төлөвшүүлэх зорилготой байгууллага юм.

Тогтвортой хөгжлийн тэргүүлэх 12 чиглэлийг баримтлан орон нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсрол, эрдэм шинжилгээ, технологи дамжуулалтын чиглэлээр инновац хөгжүүлэлтийг дэмжин ажиллаж байна. Тус төвийн үндсэн зорилго нь тогтвортой, ногоон хөгжлийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулж буй болон явуулахаар эрмэлзэж байгаа бизнес эрхлэгч, гарааны бизнес, жижиг дунд үйлдвэрлэгчид, компаниудын мэдээллийн найдвартай платформ бий болгож, тэдний үйлдвэрлэл үйлчилгээнд инновац нэвтрүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн таатай экосистем бий болгоход дэмжлэг үзүүлж байна.

Энэ төв одоогоор салбар салбарын дэвшилтэт технологи бүхий 10 гарааны бизнесийг



**ХААИС-ийн
Дархан-Уул
аймаг дахь
салбар
сургуулийн
дэргэд Европ-
Дархан Инновац
Энтрепренер-
шип Төв (ЕДИЭТ)**

бойжуулж байгаа юм. Шалгарсан 10 гарааны бизнес тус бүрд 70 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн санхүүжилт өгч инкубацийн болон хурдасгуур хөтөлбөрийн үйлчилгээ үзүүлж байна. Мөн Турк, Словени, Хорват, Бельги рүү явж туршлага судлуулж, салбар салбараар нь сургалт зохион байгуулжээ. Ази, Европ, Африкт томоохон бизнесүүдийг босгосон туршлагатай менторуудыг Европоос авчирч бизнес эрхлэгчдэдээ сургалт явуулахаас гадна Монголынхоо тухайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн экспертүүдийг урьж хичээл заалган, менторшип хөтөлбөртөө хамруулсан байна. ▶

► **Европ Дарханы Инновац Энтрепренершип Төвд бойжиж буй гарааны бизнесүүд**

- Бөднө шувууны загвар аж ахуй /Шувууны аж ахуй/
- Шимт Мөөг /Мөөгний тариалалтыг нутагшуулах/
- Чараха хүүхдийн гутал /Гутлын үйлдвэрлэл/
- Монгол сырок /Сүүн бүтээгдэхүүн/
- Цэгц савхин гутал /Гутал үйлдвэрлэл/
- Боргил саван /Олон үйлдэлт савангийн үйлдвэрлэл/
- Ихэр Дөл зуух /Давхар шаталтат утаагүй зуух/
- Даавуун живх /Живх/
- Хуванцар боловсруулах үйлдвэр /Хуванцар дахин боловсруулах/
- Үлэмж зөгийн бал /Зөгийн бал үйлдвэрлэл/
- Найрамдал мөөг /Мөөгний тариалалт нутагшуулах/
- Хөрсөн бортого /Мод тарих, хөрсөн бортого үйлдвэрлэл/
- Science Cafe

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН МОДУЛЬ ХӨТӨЛБӨР-1

Дархан-Уул аймгийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн салбарт тулгамдаж буй асуудлыг шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ, инновац, технологийн тусламжтайгаар шийдвэрлэх гарааны бизнесийн төслийг сонгон шалгаруулж өрсөлдөх чадвар бүхий бизнес болгон хөгжүүлэх, бизнесийн тогтвортой өсөлтийг хангах зорилготой сургалтыг 2022 оны есдүгээр сарын 9,10,16,17-ны өдрүүдэд зохион байгуулав.

Гарааны бизнесийн чадавхжуулах сургалтын хүрээнд 16 цагийг Бизнесийг тэгээс эхлэх тухай, Ногоон бизнес, Уламжлалт бизнес ба шинэ үеийн бизнесийн ялгаа, Шинэ санаа ба олон улсын хөрөнгө оруулалт, Инновац гэж юуг хэлдэг вэ, Бизнесмэн болон Энтрепренер гэж хэн бэ, ялгаатай юу гэх мэт ойлголтыг хамарч олгосон бөгөөд нийт 56 цагийн танхимын сургалтыг 27 сэдвийг хамарч, 8 удаа 30 цагийг танхимаар 14 цагийг цахим хэлбэрээр зохион байгуулжээ.



Демо өдрийн шалгарсан шилдэг 3 төсөл. Шүүгчдийн хамт



Шалгарсан багийн гишүүд, шүүгчдийн хамт

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН МОДУЛЬ ХӨТӨЛБӨР-2

Хүрээлэн буй орчинд ээлтэй шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ, инновац, технологи бүхий гарааны бизнесийг хөгжүүлэх сонирхол бүхий иргэд, аж ахуйн нэгжид сургалтаар дамжуулан гарааны бизнесийн суурь мэдлэг олгох, сэтгэлгээг хөгжүүлэх, чадваржуулахад чиглэсэн тус сургалт 2022 оны есдүгээр сарын 29-нөөс 2022 оны 11 дүгээр сарын 16 хүртэл зохион байгуулагдав.

Уг сургалтаар анхны сургалтын хөтөлбөрөөс олж авсан Гарааны бизнес эрхлэх суурь ойлголтын маш нарийвчлан хөтөлбөр боловсруулан, гэрийн даалгавар өгч сургалтын эцэст 12 оролцогчтой шилдэг гарааны бизнес сонгон шалгаруулах өдөрлөг зохион байгуулан гурван шилдэг гарааны бизнесийг тодруулав. ►

► УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛД ТОХИРСОН УХААЛАГ ГАЗАР ТАРИАЛАН БА АГРОПРЕНЕРШИП-3

Ногоон тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг дэвшилтэд технологи ашиглан эдийн засгийн үр ашигтай хөтлөн явуулах хандлага, боломж, арга замыг танилцуулах сургалт 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс 12 дугаар сарын 16-ны өдөр болон 2023 оны нэгдүгээр сарын 31-ны өдөр болов.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахын тулд ухаалаг газар тариалангийн технологийг Монголд нэвтрүүлэх, хөгжүүлэх хэрэгцээ, тулгарч буй асуудал ба боломжууд, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тариалангийн технологи, Ухаалаг газар тариалангийн CropX технологи /Израил технологи/, Ухаалаг хүлэмжийн технологи, Газар тариалангийн хиймэл дагуулын хяналт болон Органик хүнсний баталгаажуулалт, Агро аялал жуулчлал гэх мэт сэдвээр мэдлэг олгожээ.

ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ -4

“Найрамдал” төслийн хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд, мэргэжилтнүүдийг оролцуулан “Тогтвортой аялал жуулчлал” чадавхжуулах сургалтыг 2023 оны дөрөвдүгээр сарын 6-8-нд зохион байгуулав.

Монгол, Словени улсын нэр хүндтэй олон улсын мэргэжилтэн, зөвлөхүүд, бизнес эрхлэгчид дэлхийн жижиг хотуудын төр, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан тогтвортой аялал жуулчлалын шинэ санаа, бүтээгдэхүүн, шилдэг туршлагаудыг хуваалцав.

НИЙГМИЙН ЭНТРЕПРЕНЕРШИП ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ -5

Нийгмийн бизнес эрхлэгч, эрдэмтэн судлаачид, их сургуулийн багш нар, гарааны бизнес эхлүүлж байгаа баг хамт олон зэрэг нийгмийн тогтвортой хөгжлийг бий болгох, инновац, үнэт зүйлсийг бүтээхийг зорьж буй 56 оролцогчийг чадавхжуулах "Нийгмийн Энтерпренершип" сургалт 2023 оны есдүгээр сарын 9-10-ны

ЕДИЭТ нь Дархан бүс нутагт тогтвортой хөгжлийн 12 тэргүүлэх чиглэлээр сургалт, санхүү, техникийн туслалцаа үйлчилгээний экосистем бүтээнэ.

-  Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах түүнд дасан зохицох, тэсвэрлэх чадвартай инновац
-  Тогтвортой үйлдвэрлэлийн инновац
-  Уур амьсгалын өөрчлөлтөд тохирсон тогтвортой хүнс үйлдвэрлэл
-  Цэвэр агаар ба инновац
-  Засаглал, иргэдийн үйлдвэрлэл эрхлэлт, технологийн хөгжил дэмжих инновац
-  Нүүрстөрөгчийн ялгарал багатай бүтээн байгуулалтын инновац
-  Байгальд түшиглэсэн эдийн засгийн инновац
-  Түүхий эдийн тогтвортой нөөцийн инновац
-  Тогтвортой хотын ухаалаг, цахим шилжилт, нийтийн тээврийн шинэчлэл
-  Ухаалаг, цахим инновац
-  Тогтвортой аялал жуулчлал, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн инновац
-  Хаягдалгүй, тойрог эдийн засаг

хооронд зохион байгуулагдлаа. Энэхүү сургалт нь Энтерпренер судлаач хөтөлбөр, Эрдэм Идеатон болон Нийгмийн Энтерпренершип чадавхжуулах сургалтуудыг агуулан 2023 оны тавдугаар сарын 29-нөөс есдүгээр сарын 10 хүртэл үргэлжиллээ.

ИРГЭД БОЛОН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ-6

"Төрийн албан хаагчдын болон иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх" цогц хөтөлбөрийн эхний сургалтыг Дархан-Уул аймгийн ЗДТГ-т танхимын ►

► хэлбэрээр 2023 оны аравдугаар сарын 12-нд зохион байгуулав. Энэхүү хөтөлбөр долоо хоног бүр цахим сургалтаар орж 11 дүгээр сарын 13-нд нийт 47 оролцогчдодоо сургагч багш нарын гэрчилгээ гардуулав.

Сургалтын хүрээнд төрийн албан хаагч нар "хүн төвтэй дизайн сэтгэлгээ"-ний аргачлалыг ашиглан 300 орчим ТАХ-ын бодит эрэлт хэрэгцээнд үндэслэн ирээдүйд чиглэсэн, богино хугацааны сургалтын жишиг хөтөлбөрийн агуулга, форматын саналыг өөрсдөө боловсруулан аймгийн удирдлагуудад танилцууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ТЕХНОЛОГИ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ -7

“Найрамдал” төсөл, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв болон Дархан-Уул аймгийн Байгаль орчин Аялал жуулчлалын газартай хамтран “Байгаль орчинд ээлтэй технологи” сургалтын эхний хэсгийг 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулж, 38 оролцогчийг хамруулав.

Сургалтын хоёр дахь хэсгийг 2024 оны нэгдүгээр сарын 12-нд “Уур амьсгалын өөрчлөлт, түүх, үр дагавар, дасан зохицохуй, түүний өөрчлөлтийг сааруулах болон бид юу хийж чадах”, “Нөхөн төлжих хөдөө аж ахуй ба ухаалаг газар тариалан, мал аж ахуйн цогцолбор байгуулах асуудал болон сайн туршлагууд”, “Ногоон санхүүжилт” сэдэвт хичээлээр зохион байгуулсан ба 80 гаруй хүн оролцов.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА СУРГУУЛИЙН ОРЧИНД ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ, ТОГООЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ-8

Европ-Дарханы Инновац Энтрепренершип төв ээлжит сургалтаа Beyond Nutrition төсөл, Дархан-Уул аймгийн Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран “Хүнсний аюулгүй байдал ба сургуулийн орчинд үйлчилгээ эрхлэгч, тогооч нарыг чадавхжуулах” сэдвийн дор 2024 оны дөрөвдүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Политехникийн коллежийн тогооч бэлтгэх сургалтын танхим, Залуучууд театр болон 12 сургуулийг оролцуулан зохион байгууллаа.

Энэхүү сургалт нь Дархан-Уул аймгийн сонгогдсон сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны амт чанарыг дээшлүүлэх, эрүүл аюулгүй хоол хүнсээр хангах тогтолцоог үнэлэлт зөвлөмж, цаашлаад сурагч хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэг

оношилгоог хийж, гэр бүл эцэг эхчүүдэд нь эрүүл мэндийн боловсрол олгох зорилготой байв.

ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ-9

“Найрамдал” төслийн Европ Дарханы Инновац Энтрепренершип төвийн ээлжит сургалт болох Гарааны бизнесийн чадавхжуулах сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд Испани улсын ментор Анхел Мануэл чиглүүлэн явуулав. Энэ сургалтаар Европын бизнесийн ухагдахуун, орчин нөхцөл, экосистемийн ойлголтыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой байлаа. ■

“Найрамдал” төслийн Европ Дарханы Инновац Энтрепренершип төвийн сургалтад оролцогчдын сэтгэгдлээс хүргэе.



Д.Чадрабал
/Уул уурхай, эрчим хүчний Политехник коллежийн захирал/

Хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалт хэрхэн татах, боловсруулж байгаа бүтээгдэхүүнээ яаж хамгаалах вэ гэдэг чиглэлээр хоёр өдрийн сургалтад хамрагдаж байна. Маш үр дүнтэй сургалт боллоо.



Б.Мөнх-Эрдэнэ
/Hydro Buds LLC-ийн менежер/

Судлаач энтрепренерүүд гэдэг хөтөлбөрт хамрагдсан. Лхагва гараг бүр онлайнаар хичээлд суудаг. Энэ хөтөлбөрт хамрагдаад энтрепренерүүд гэж хэн бэ, хэрхэн хөрөнгө оруулалт татах вэ, технологи яаж үүсдэг вэ, зохиогчийн эрх болон зах зээлд хэрхэн нэвтрэх үү, маркетингийнхаа загварыг яаж гаргах вэ зэрэг маш олон мэдээллийг нэг дор авлаа.



Б.Болдбаатар
/Дархан ПК-ийн сургалтын менежер/

Санхүү эдийн засгийн их сургууль болон Шинжлэх ухааны академиас хамтран зохион байгуулж байгаа Оюуны өмчийн талаар болон инновац шинэ бүтээл, шинэ санааг хэрхэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх вэ, төр, хувийн хэвшил болон судалгааны байгууллага хэрхэн хамгарч үйл ажиллагаа явуулснаараа инновацлаг буюу шинэлэг бүтээлүүдийг гаргах вэ гэдэг талаар амжилттай сургалтуудыг явуулж байна. Мөн энэхүү сургалтад хамрагдсанаар тухайн бүтээл маань цаашдаа өргөжиж дараагийн шатны арга хэмжээнүүдэд оролцох боломжийг бүрдүүлж байгаа нь таатай байна.

Шигтгээ үг

“Найрамдал” төслийн зохион байгуулсан чадавхжуулах сургалтуудын ментор, багш нарын онцлох ишлэлүүдээс хүргэе.

Б.Солонго:

"Тийм көүчинг" компанийн захирал



Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчид маань бүгд өөр өөр ажлын газар, албан тушаалтай холимог групп байгаа. Олон талт ялгаатай байдал, оролцоо, олон ургалч үзэл, хүйсийн тэнцвэртэй байдал, үе хоорондын ялгаа гэсэн санаануудыг өөрсдийн багийн бодит кейс дээрээ багийн көүчингийн аргачлалаар үзсэн байгаа. Цаашдаа оролцогч нар маань сургалтаар олж авсан мэдлэг, ойлголтуудаа ажлын байран дээрээ түгээн дэлгэрүүлж, өөрсдөө манлайлаад явах ач холбогдолтой юм.

Б.Буянбадрах:

Аялал жуулчлалын зөвлөх



Эвент дангаараа үйлдвэрлэл болж хөгжиж байна. Дархан хот нь зам харилцаа, зочид буудал, рестораны хүртээмжээр давуу талтай тул олон төрлийн эвент зохион байгуулах боломжтой. Эхлээд эвентийн шалтгаан, үр дүн, цар хүрээ, төлөвлөлт, хүний нөөцийг бүрэн тодорхойлох нь чухал юм. Эвентийг 2-48 сарын өмнөөс бэлдэж зарладаг. Зочин, жуулчны байр сууринд өөрийгөө тавьж эвентээ зохион байгуулах хэрэгтэй.

Г.Батхуяг:

Санхүү, эдийн засгийн их сургуулийн ахисан түвшний сургалт, судалгаа хариуцсан проректор Ph.D



Гарааны бизнес эрхэлдэг хүмүүсийн хувьд бүтээгдэхүүний хөгжүүлэлт дээрээ гол эрсдэл гаргадаг байгаа. Яг зах зээлийнхээ эрэлт хэрэгцээнд таарч, нийцэж чадаагүй бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлээд, тэр дээрээ хөрөнгө оруулалт хийгээд, бизнесээ эхлүүлдэг. Энэ нь эргээд эрсдэх магадлалд ордог. Бид сургалтаараа тэр эрсдэлийг аль болох багасгах тал дээр фокуслаж байна.

Л.Энхтуяа:

Органик хөгжил ХББ-ын гишүүн



Дархан-Уул аймгийн хувьд Монгол Улсын газар тариалангийн бүс гэж ойлгодог. Тэгэхээр манай өрхийн тариаланчид маань жижиг органик фермерийг сонгох нь зүйтэй. Нэгэнт өрхийн аж ахуй эрхэлж байгаа тохиолдолд аль болох эрүүл, байгальд ээлтэй сонголтыг хийж, үүнийгээ давуу тал болгон хөгжүүлэх нь бүх талаараа үр дүнтэй. Органик тариалалтыг хүнсний аюулгүй байдалтай холбох нь байгалийн нөөцийг тогтвортой, зохистой хүртэх гарц гаргалгаа юмаа.

Яана Апил:

Словени Улсын аялал жуулчлалын “Түүд плейс” компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал



Аяллын утга учир нь дурсамж бүтээж, түүхийг нь сонсоход оршдог. Мөрөөдлөө биелүүлэхэд аялал жуулчлал тусалдаг. Учир нь та юу хийж, үйлдвэрлэж чадах уу тэрийгээ тууштай бүтээ, зөгийгөө үржүүл, ногоогоо тарь, талхаа барь. Аялал жуулчлал бусдыг нь хийнэ. Хайр гэдэг үг орсон ганц л улс энэ дэлхий дээр бий. Тэр бол Slovenia.

О.Энхзул:

Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын албаны дарга



Төрөөс гаргаж байгаа бодлого шийдвэрт үр шим хүртэх ёстой нийгмийн бүлгүүд, иргэд, аж ахуйн нэгж, олон нийт нь төлөвлөхөөс эхлээд хэрэгжүүлэх, хянах, сайжруулах процесст тэгш оролцоход технологийн чадвар шаардлагатай байдаг. Тиймээс үр дүн гаргахын тулд нэг талаас иргэд, нөгөө талаас төрийн албан хаагчид буюу энэ процесст оролцож байгаа талуудыг орхигдуулахгүй хамтад нь чадавхжуулах нь чухал.

Т.Дөлгөөндусал:

Боловсролын санаачилгууд ТББ-ын хөтөлбөр хариуцсан захирал



Асуудлыг шийдвэрлэхдээ загварчлах сэтгэлгээ ашигласнаараа илүү үр дүнтэй шийдэл боловсруулах давуу талтай байгаа. Үүнийг нэг тод жишээ бол Найрамдал төсөл гэж бодож байна. Учир нь гурван жилийн турш төслөө хэрэгжүүлэхдээ Дархан-Уул аймагт хаана, ямар асуудал байгааг, яаж шийдэж болох зэргийг маш сайн олж харж, боловсруулсан тул яг зорилтот буюу хүрэх ёстой иргэддээ ашигтай, үр бүтээмжтэйгээр хүрч ажиллаж байгаа гэж харж байна.

Г.Оюунгэрэл:

"ХайтлПак" ХХК, "Хөгжлийн Тэгш Санаачилга" ТББ-ын гүйцэтгэх захирал



Бүтээлч сэтгэлгээ гэдэг бол бүх хариултыг мэдэх бус харин хариулт заавал олдоно гэсэн тууштай итгэл юм. Ямар нэгэн зүйлийг олон талаас харах нь бүтээлч сэтгэлгээг өдөөдөг.

Ш.Алтанбадралт:

"М Агро" ХХК-ийн Газар тариалан, технологийн албаны дарга



Монгол Улсын хөдөө аж ахуйн өнөөдрийн тогтолцоо дэлхийн дулаарал, байгаль орчны өөрчлөлттэй шууд уялддаггүй. Өөрөөр хэлбэл, бид уламжлалт, социализмын үеэс хөгжүүлж ирсэн хөдөө аж ахуйн хөгжлийн концепцыг баримтлан явж байна. Тэгэхээр бид ийм түргэн хугацаанд өөрчлөгдөж байгаа байгаль цаг ууртай холбогдуулан хөдөө аж ахуйн менежментийн тогтолцоог сайжруулах шаардлагатай болж байна.

Д.Буян:

Швейцар улсын мэргэжлийн тогооч, сургагч багш



Эрүүл мэндийг, эрүүл гал тогооноос л авна. Эмийн сангаас бус. Бидний хийдэг түгээмэл алдаанаас дурдвал малын хөдөлгөөн ихтэй хэсэг буюу гуя, цорой, хаа болон хүзүү хэсгийн мах нь хатуу байдаг тул зөвхөн нэгдүгээр хоол буюу соуслаг хоол хийнэ. Энэ хэсгийн мах нь collagen болон желатинаар баялаг байдаг тул тодорхой хугацаанд шингэнтэй буцалгаж байж задран, ходоодонд ороод хэрэгтэй шим тэжээлээ өгдөг. Харин бид гуяны махаараа цуйван хийгээд бүх шим тэжээлийг гаргаад хаячихдаг.

Анхел Мануэл Сотос Пиерто:

Испани улсын "ВИ ТИ ЭЛ" ХХК-ийн үүсгэн байгуулагч



Бизнес эрхлэхээсээ өмнө та дараах асуултыг өөрөөсөө асуугаарай Та хайрцаасаа хальж сэтгэж чаддаг уу? Нэгэн хэвийн хэвшмэл ойлголт, хэрэглээг таны бизнес санаа хир өөрчилж чадах вэ? Харин дараа нь таны бизнесийн санаа нийгэмд ямар өөрчлөлт бий болгох вэ? Гэх асуултад хариулах дараалалтай гэж боддог.

Хөрсөн бортого

"Хөрсөн бортого" үйлдвэрлэгч

"Хөрсөн бортого" төсөл нь био нүүрсний агууламжтай хөрсөн бортого үйлдвэрлэх замаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилготой. "Их мориг" компанийн захирал "Хөрсөн бортого" төслийг хэрэгжүүлж буй Б.Бадрахмаатай ярилцлаа.

-Компанийнхаа талаар эхлээд танилцуулахгүй юу?

-Манай компани тахианы аж ахуй эрхэлж, хүнсний өндөг үйлдвэрлэдэг. Мөн орчин үеийн хүлэмжийн аж ахуй эрхэлдэг. Дархан-Уул аймагтаа хүнсний өндөгний 40 хувийг, мөн нарийн ногооны тодорхой хувийг хангадаг. Тахианы чиглэлээр 2011 онд байгуулагдаж, үйл ажиллагаагаа тууштай явуулж байна. Үр дүнд нь "Дархан өндөг" брэнд бий болсон. Хүнсний ногоонууд маань сайхан ургаж байна.

-"Найрамдал" төсөлтэй хэрхэн яаж холбогдсон бэ?

-Тахианы фермээс маш их тахианы сангас гарч, үр ашиггүй хаягддаг. Уг нь тахианы сангас тэр чигээрээ бордоо, аммиак болдог учраас хэрэгтэй хог хаягдал гэж үздэг. Үүнийг эргээд



Бид төслөө бичихийн тулд гурван сарын хугацаанд "Найрамдал" төслийн сургалтуудад суусан. Төслөө хэрхэн бичихээс эхлээд маш их мэдлэг, мэдээлэл олж авсан, үр дүнтэй сургалтууд байсан

хэрхэн ашиглах вэ гэдэг чиглэлээр бид судалж ажилласан юм. Энэ үеэр Дархан-Уул аймаг дахь ХААИС дээр Европын холбооны "Найрамдал" төслийн хүрээнд уралдаан зарласан. Тэгээд бид сангасаа боловсруулж, био нүүрс гаргаад хөрсөн бортого хийх төслөө бичиж явуулсан.

Дүрсэлж хэлбэл, хаягдаж байсан тахианы сангасаа дахин боловсруулаад био нүүрс гаргана. Био нүүрсээ хар шороо, гумин, барьцалдуулагч бодис, ургамалд хэрэгтэй шим тэжээлтэй бодисуудыг холиод хэвлэдэг машинд оруулж, хэвлээд бортого хэлбэртэй бүтээгдэхүүн хийнэ гэсэн үг. Бид өмнө нь Монголд хийж байгаагүй шинэ инновацыг үйлдвэртээ нэвтрүүлсэн. Манай том ах био нүүрсний чиглэлээр мэргэшсэн Мөнхбат гэж профессор байдаг. Судалгаа хийгээд патентаа авчихсан ажил байсан юм. Бид ахынхаа оюуны бүтээлийг бодит амьдралд хэрэгжүүлэх үүднээс төсөл болгож бичээд "Найрамдал" төсөлд шалгарч, Гран при шагналыг авсан.

-20 мянган еврогийн буцалтгүй санхүүжилт авсан гэсэн. Одоо танай төсөл хэр амжилттай явж байгаа вэ?

-"Найрамдал" төсөлд 2023 онд шалгарсан нь бас учиртай. Бид төслөө бичихийн тулд гурван сарын хугацаанд "Найрамдал" төслийн сургалтуудад суусан. Төслөө хэрхэн бичихээс эхлээд маш их мэдлэг, мэдээлэл олж авсан, үр дүнтэй сургалтууд байсан.

20 мянган еврогийн санхүүжилтээрээ төслөө эхлүүлсэн. Тахианы сангасаа байгалийн аргаар хэвлэж хатаагаад, дараа нь зууханд сангасаа шатааснаар био нүүрс бэлэн болдог. Био нүүрс юунд хэрэгтэй вэ гэхээр сайн чанарын бордоо болдог. Хүлэмжид ашиглаж болж байна. Газар ►



Зөгийн бал

► тариалангийн компаниуд хөрсөө сийрэгжүүлэх, чийгийг нь удаан барих, хөрсний бүтцийг зөв болгоход хамгийн чухал бүтээгдэхүүн гэж үздэг.

Био нүүрсээ хөрс болон бусад бордоотой хольж хэвлэж хатаагаад бортого үйлдвэрлэсэн. Бортого маань уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад маш хэрэгтэй бүтээгдэхүүн. Манай бортого голдоо нүхтэй. Тэр нүх рүү ямар ч хамаагүй модны үрийг суулгахад гурван жил ургах мод зургаан сар ургаж байна. Маш хурдтай ургана. Гол учир нь үндэс нь голлож ургадаг. Уламжлалт аргаар тарьсан модны үндэс нь салаалж ургадаг. Салаалж ургасан ургамал нь газрын гүнээс ус, чийгээ хангалттай авч чаддаггүйгээс амьдрах чадвар сул болдог. Харин манай бортогонд суулгасан үр голлож ургадаг, мөн био нүүрс нь ус чийгийг барьж, хөрсийг сийрэг байлгадаг ач холбогдолтой учраас маш хурдтай ургадаг гэсэн үг. Бид шинэс, хайлаас, монос, буйлс, гүйлс, агч гээд олон төрлийн модны үрийн бортогондоо суулгаж үзсэн. Нийтдээ таван мянган ширхэг бортогонд олон төрлийн модны үрээр туршилт хийсэн. Ингэхэд манай моднууд үнэхээр сайн ургаж байсан. 2024 оны зунаас ургуулж эхэлсэн дээ.

-Бортогоо олноор үйлдвэрлэе гэвэл томоохон хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл хэрэгтэй болох байх. Цаашдын зорилго юу вэ?

-Бидэнд юу дутагдаад байна вэ гэхээр дөрвөн тонн сангас шатаах зуух хэрэгтэй байгаа. Одоогоор туршилтын жижиг зуухаараа ажиллаж байна.

“Найрамдал” маш үр дүнтэй, өгөөжтэй төсөл. Зүгээр туршилт хийгээд орхих биш эргээд дараагийн түнш юу билээ, цаашид хэрхэн хөгжих вэ гэдгийг хүртэл зааж чиглүүлж байдаг. Тус төслийн шугамаар Солонгос, Европ, Турк руу явсан. Ижил төрлийн үйлдвэрлэл хэрхэн явж байгааг бодитоор явуулж үзүүлдэг нь маш том оюуны хөрөнгө оруулалт болсон. Уг төслийн зөвлөх Камлеш Кумар Патак манайхыг маш их сонирхож байгаа. Тахианы сангасыг хаяхгүйгээр эргүүлэн боловсруулж бортого гаргаж байгаа нь дэлхийн ногоон хөгжилд маш том хувь нэмэр оруулах бизнес юм. Тиймээс зөвхөн сангас биш малын өтөг бууц, модны холтсыг ашиглаж юу хийж болох талаар төсөл бичиж, дараагийнхаа хөрөнгө оруулалтыг татах талаар яриад явж байна. ■

Х.Золзаяа: “Найрамдал” төсөл бизнес эрхлэгчдийн харах өнцгийг өөрчилсөн



“Тэс оргил” ХХК-ийн захирал Х.Золзаяатай ярилцлаа.

-Та “Найрамдал” төсөлтэй хэрхэн холбогдож энэхүү төслийн нэг гол оролцогч болсон бэ?

-Миний хувьд 2012 оноос өрхийн хэмжээнд аж ахуй эрхэлж эхэлсэн. 2017 оноос компанийн үйл ажиллагаанд оруулан өргөжиж, Үлэмж зөгийн бал нэрээр бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулж байна. Хамгийн чанартай, ямар нэг технологи ажиллагаанд оруулаагүй, монгол амт онцлог бүхий бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх зорилготой үйл ажиллагаагаа эхэлж байсан. Харин “Найрамдал” төсөлтэй холбогдсоноор зөвхөн зөгийн балаас гадна өөр ямар инновац шингэсэн бүтээгдэхүүн байж болох уу гэдэг дээр эрэл хайгуул хийгээд ажиллаж байна. ►

► Анх Орхон сумын ИТХ-ын дарга ийм төсөл хэрэгжих гэж байна гэж санал болгосон. Өмнө нь олон төслийн мэдээлэл дээр очдог, ирц гүйцээх гэж ороод явдаг байсан учир нэг их ач холбогдол өгөөгүй. Дараа нь Халамжийн мэргэжилтнийг хэлэхээр дахин очсон юм. Гэтэл уг төсөл Дархан-Уул аймгийг ногоон эдийн засгийн хүрээнд дэмжин ажиллах гэж буй Европын холбооны төсөл юм байна гэдгийг ойлгосон. Тэгээд сургалтуудад нь сууж, эхний шатны төслийн шилдэг оролцогч болсон. Хоёр дахь шатанд манай төсөл гарааны бизнесийн шилдэг төслөөр шалгарсан. “Найрамдал” төслийн хүрээнд хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээг ойртуулах, мэдээ мэдээлэл өгөхийн тулд Ulemj Mongolian pure honey пэйж, ulemjhoney.com сайтыг ажиллуулж байна. Сайт дээрээ Үлэмж зөгийн балын бүх бүтээгдэхүүнээ төрөл бүрээр нь ялган тайлбарласан байгаа. Хэрэглэгчид сонголтоо хийгээд хүргэлтээр авах боломжтой. Мөн бид зөгийн аж ахуй эрхлэх гэж буй хүмүүст зориулсан сургалт явуулахаар нэгдсэн.

–“Найрамдал” бусад төслөөс юугаараа ялгаатай вэ. Та бүхэнд ямар үр шим өгсөн бол?

–Өмнөх төслүүдийн хувьд тайлан маягийн зүйл сонгоод, нэг удаагийн сургалт хийгээд л өнгөрдөг байсан. Харин энэхүү төсөл жижиг, дунд бизнес эрхлэгчид бодит хувь нэмэр оруулсан. Бизнес эрхлэгчдийн харах өнцөг өөрчлөгдсөн гэж бодож байна. Учир нь бизнесийн ашиг орлогоос гадна нийгэмд би ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ гэдэг

**“Найрамдал”
төсөл жижиг,
дунд бизнес
эрхлэгчид
бодит хувь
нэмэр оруулсан**

талаас харж эхэлсэн. Олон хүнд хүртээмжтэйгээр, бусадтай хамтраад яаж ажиллаж, ашиг орлого олж, түүнээсээ хамтдаа үр шимийг нь хүртэх үү гэдэг шинэ санаа сэдлийг авсан. Төслийн хүрээнд Улаанбаатараас тухайн салбарын олон сайн мэргэжилтэн ирж сургалт хийсэн. Бид өмнө нь 40-өөд бүлтэй байсан бол төсөл хэрэгжсэнээр 90-д хүрсэн. Будаг шохойтой өрөөнд гар ажиллагаагаар бүтээгдэхүүнээ савладаг байсан бол Европын холбооны санхүүжилтийн тусламжтайгаар шинэ тоног төхөөрөмжтэй болсон.

Манай аймаг зах зээл жижиг. Тиймээс дотоодын зах зээлээ хамгаалах бодлого явуулах нь зүйтэй санагддаг. Төрийн албанд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн худалдан авалт хийгээсэй. Мөн бизнес эрхлэгчдийг хооронд нь холбосон, дэмжсэн арга хэмжээ зохион байгуулах нь ач холбогдолтой.

–Та бүхэнд бүтээгдэхүүнээ гаднын зах зээл рүү экспорт хийх төлөвлөгөө байгаа юу?

–Тийм бодол бий. Гэхдээ бидний үйлдвэрлэл жижиг шүү дээ. Манай аймгийн ХААИС дээр хэрэгжиж буй хөтөлбөрийн хүрээнд Япон руу нэг дээж явуулсан. Монголын зөгийн бал ийм шинж чанараараа давуу байна гэсэн хариу ирвэл их хэмжээгээр биш ч Японд савладаг юм уу, ямар нэг хэмжээгээр гадагш зүглэх зам нээгдэх байх. Мөн өөр улсад гаргахын тулд дан ганцаар биш зөгийчид хамтран бүлэг болох, илүү бүтээмжтэй байх үйлдвэрлэлийн сонголт хийх хэрэгцээтэй байна. ■



Мөөг

Б.Алимантуяа: Яг шантраад урам хугарах үед “Найрамдал” төсөлтэй холбогдсон

“Найрамдал мөөг” ХХК-ийн захирал Б.Алимантуяатай ярилцлаа.

-Танай компанийн нэр ч Найрамдал юм байна. Танай компани “Найрамдал” төслөөс хэрхэн яаж санхүүжилт авч чадсан бэ?

-Нэрийн хувьд санаандгүйгээр адилхан юм аа. Би 2021 онд анх аймагтаа мөөг тарихаар зар тавьж хүмүүс цуглуулж сонгон шалгаруулалт хийж байлаа. Сонгосон хүмүүсээрээ баг бүрдүүлэн хоршоо байгуулсан. Дархан-Уул аймаг маань газар тариалангийн бүс учраас мөөг тариалах хамгийн боломжтой гэж үзээд болно, чадна гэсэн сэтгэлээр энэ салбарт хөл тавьсан.

Анх Хятадад сурч байхдаа Монголоос байнга мах зөөх хэцүү учраас мөөг иддэг байлаа. Мөөг идэхээр бие хөнгөрөөд их сайхан байдаг байсан. Монголдоо ирээд мөөг худалдаж авах гэтэл лангуун дээр хэд хоносон нь ч мэдэгдэхгүй харласан мөөг байсан. Хаанаас шинэхэн мөөг авах вэ гэдэг асуулттай тулсан.

Харин манай аймагт байгалийн хог хаягдал ихтэй, үүнийг ашиглаад мөөг тарих боломжтой, туршаад тарьж үзсэн хүмүүс бий гэж сонссон юм. Ингээд нутаг орондоо ажлын байр бий болгож, орон нутгийн хөгжилд жаахан ч болов хувь нэмэр оруулах зорилготой хоршоогоо үүсгэн байгуулж байсан. Гэтэл олон асуудалтай тулгарсан. Хоршоо зээл авах боломжгүй. Нэмэлт санхүүжилт гаргах боломж ч бидэнд байхгүй байв. Нутагтаа юм хийж бүтээх хүсэл эрмэлзлэлдээ хөөрсөн залуу хүний хувьд, мөн мөөг шинэ салбар учраас хүнд асуудлуудтай тулаад шантарч ирдэг юм билээ.

Яг энэ үед “Найрамдал” төсөлтэй холбогдсон. Ингэснээр гарааны төсөл, бүтээгдэхүүн үйлчилгээ сав баглаа боодлын стандарт, төслөө яаж бичих ёстой гээд анхан шатны бүх л мэдээлэл авч, сургалтуудад хамрагдсан. Гарааны бизнесийг хэрхэн яаж хийх ойлголтой болсон. Манайх эхний шалгаруулалтад дөрөвдүгээр байрт орсон. Эхний гурван байр л тэнцэх ёстой байв. 2023 онд дахиж төслөө бичиж ороод Ухаалаг хүлэмж төрөлд шалгарсан.

-Энэхүү төслийн хүрээнд Хятад улсад



“Найрамдал” төсөлд үнэхээр сэтгэлтэй удирдлага, мэргэжилтнүүд ажилладаг. Бидэнтэй байнгын холбоотой байж, мэдээлэл өгч, хянаж, зөвлөдөг. Маш том урам зориг, бойжуулалт болж чадсан

туршлага судалсан гэж сонссон юм байна.

-Бид Хятад улсад 12 төрлийн мөөг тариалах сургалтад хамрагдсан. Маш их мэдлэг мэдээлэл өгсөн сургалт болсон. Одоо бид дөрвөн улирлын ухаалаг хүлэмжээ бариад байна. Өмнө нь түрээсийн хүлэмж ашиглаж байсан. “Найрамдал” төсөлд үнэхээр сэтгэлтэй удирдлага, мэргэжилтнүүд ажилладаг. Бидэнтэй байнгын холбоотой байж, мэдээлэл өгч, хянаж, зөвлөдөг. Маш том урам зориг, бойжуулалт болж чадсан.

Одоо бидний хамгийн ихээр баярлаж байгаа зүйл бол хоршооноос компани болон өргөжлөө. Үйл ажиллагаагаа тэлэхийн тулд дөрвөн улирлын хүлэмжээ барьцаалаад ЖДҮ-ийн зээл рүү материалаа өгөөд хүлээж байна. Дараагийн томоохон санхүүжилт авах эрх үүссэн. “Найрамдал” төслийн үр шим бидэнд ийм нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Би азтай. Ер нь төсөлд тэнцсэн бүх хүн азтай гэж бодож байна. Миний хувьд энэ төсөлтэй холбогдоод, сургалтад нь суугаад, санхүүжилт авч, бизнесээ босгоод, үр шимийг нь хүртээд явж буйдаа үнэхээр талархалтай байгаа. Төслийн удирдагч, ажилтнууд шалгарсан төслүүдийг бойжуулж, үр шимийг нь нийгэмд яаж хүртээх үү гэдэгт ихэд анхаарч, сэтгэлээ чилээдэг хүмүүс. Шөнө орой ч утасдахад тулгамдсан асуудлаар зөвлөж ирсэн. Мөөгний салбарт мини кластер чиглэлээр ажиллаа ▶



► гэхэд кластерийг яаж авч явах ёстой талаар зөвлөгөө өгөөд явж байна. Улаанбаатараас багш нарыг авчирч зөвлөгөө сургалт зохион байгуулж байна.

Миний хувьд ганцаараа мөөг тариад ганцаараа мөнгө төгрөгтэй болж баяжъя гэхээсээ илүүтэй ажлын байр бий болгоё, импортын мөөгийг дотоодоос хангадаг болгоё, мөөгний үйлдвэрлэлийг хөгжүүлж гэж зорьсон.

-ЖДҮ-ийн зээл аваад үйлдвэрлэлээ хэрхэн

хөгжүүлэхээр төлөвлөж байна вэ?

-ЖДҮ-ийн зээлийг хөрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулна. Мөөг тарих, талбай, газар, мөөгийг хэрхэн тарих сургалт, судалгааг хийнэ. Бид бүтээгдэхүүнээ өнөөдөр Дархан сумын 10 орчим дэлгүүрт өгч байна. Тариалалт маань бага байгаа. Төслийн ачаар хүлэмжээ барьж дуусгаж байна. Одоо хөрсний үйлдвэрээ барьж тариалалтыг нэмэгдүүлж, Дарханы нэг томоохон брэндийг бий болгох зорилготой ажиллаж байна.

Монголчууд бид жилийн дөрвөн улиралд мах иддэг. Махны хэрэглээ 2.6 дахин их. Маш их баялагтай мөртлөө ядуурлын түвшингээр өндөр яваа орон. Надаас шалтгаалах юу байна гэхээр чаддаг юм аа хийе, зааж, сургая. Олон хүнтэй нийлж, хамтраад явъя. Хөгжье гэж бодсон.

Мөөг нь дархлааны системийг сайн төлжүүлдэг, В-гийн төрлийн витамин өндөртэй. Ядаргааг тайлж, ходоод, хоол боловсруулах эрхтэнд эерэг нөлөөтэй гэж үздэг. Мөөг бүх төрлийн махан хоолтой адилхан бүх хоол, кето хоол, веган хоол гээд хийж болдог. Би мөөгийг махтай холиод ид гэж зөвлөдөг. Шингэц сайжирна. Мөн биеэс хор гадагшлуулдаг. “Мөөг бол шидтэн. Монгол мөөгөөр ходоодоо чимээрэй” гэж уриалмаар байна. ■

Утаагүй зуух

Э.Баатар: “Ихэр дөл” зуух нүүрсээ өөрөө коксжуулж, утаа бага ялгаруулдаг

Хатуу түлшинд зориулсан давхар шаталтад утаа бага ялгаруулдаг зуухыг зохион бүтээсэн “Ихэр дөл” компанийн захирал Э.Баатартай ярилцлаа.

-Та зуухаа хэдэн онд зохион бүтээсэн бэ. Зуухны гол онцлог нь юу вэ?

-Анх “Ихэр дөл” зуухыг 2015 онд ажлынхаа туршлагад үндэслэн зохион бүтээсэн. Би өөрөө коксын зуухны машинист, дулааны техникч мэргэжилтэй хүн. Түүнээс хойш туршилт, судалгаа хийж явсаар 2019 онд өрхийн үйлдвэрлэлээр зуухаа хийж эхэлсэн. Харин “Найрамдал” төсөл хэрэгжсэнээр сургалтад хамрагдаж, компаниа ►



► байгуулж, албан ёсоор үйл ажиллагаа явуулж байна. Гарааны шилдэг бизнесийн грандыг манай бүтээгдэхүүн авсан. Одоо Монгол Улсын 20 аймагт манай зуухыг ашиглаж байна. Манай зуух сайжруулсан түлшинд үнэхээр сайн шүү.

Зуух маань хоёр процессын шаталт хийдэг. Дээрээсээ доош чиглэлд шатаад буцаад нүүрсээ боловсруулаад эргүүлээд доороосоо дээшээ гэсэн үндсэн хоёр процессын шаталт хийдгээрээ бусад бүтээгдэхүүнээс онцлог давуу талтай. Дээрээсээ шаталт явахаар нүүрсээ ангижруулаад харьцангуй цэвэршсэн нүүрсээ дахин шатаадаг гэсэн үг. Тэгэхээр 80 хувьд утаа байхгүй гэж ойлгож болно.

Өөрөөр хэлбэл, нүүрсэнд маш олон төрлийн химийн элементүүд байдаг. Тэр нэгдлүүд доороос шатаахаар утаатайгаа хамт дээшээ дэгддэг. Гэтэл дээрээс доош чиглэлд шатаахаар химийн нэгдлүүд галын дөлний дор ууршилт явагдаж байдаг. Доороо очингуут коксжих процесс дуусаад ялгарсан коксоо дахин шатаадаг. Нэг ёсондоо шуудай түлш хийлээ гэж бодоход хоёр үржүүлж шатаадаг. Түлш бага зарцуулж, дулааныг удаан барина. Манай зууханд хийсэн түлш хамгийн багадаа 12 цаг дулаанаа барьдаг. Зарим газар хамгийн дээд тал нь 36 цаг шатаж байгаа.

Ердийн зууханд урд нь 80 тонн түлш шатааж байсан объект манай зуухаар 30-50 тонн түлш шатааж байна. Объект хэрэглээ томрох тусмаа илүү их хэмнэлт гаргах хэрэгтэй болдог. Тэгэхээр уурын зуухнуудыг шинэчлээд манай зуухны зарчмаар явуулбал түлш хэмнэх боломжтой. Энэ бол бүтэхгүй зүйл биш.

–“Найрамдал” төсөлд хамрагдаад компаниа байгуулсан гэж байна. Ер нь энэ төслөөс юу сурсан бэ?

–Бизнесээ яаж удирдах уу, хэрхэн зах зээлд нэвтрэх үү зэрэг сэдвийн хүрээнд бүх сургалтад нь хамрагдсан. Солонгос, Бельги улсууд руу яваад ирсэн.

Манай П.Мэнд-Амгалан доктор олон талын мэдлэгтэй, үнэхээр мундаг боловсролтой хүн. Жинхэнэ тэргүүний сэхээтэн гэж хүндэлж явдаг. Ер нь “Найрамдал” төслөөс өмнө санаа байгаад байдаг, чиглүүлэгч хүч л дутаад байсан юм билээ. Хүмүүсийг мэргэшүүлж, зах зээл дээр бодит бизнес болгож гаргаж ирж байгаа нь энэ төслийн буян. Төсөлд хамрагдахаасаа өмнө ямар байсан одоо ямар болсноо харвал хол зөрүүтэй. Хөгжих боломж их байна. Ганцхан судалгааны байгууллага ийм төсөл аваад ийм том хөрөнгө

Манай зууханд хийсэн түлш хамгийн багадаа 12 цаг дулаанаа барьдаг. Зарим газар хамгийн дээд тал нь 36 цаг шатаж байгаа

оруулалтыг бий болгоно гэдэг үнэхээр сайн хэрэг. Төрийн зүгээс үүн дээр маш сайн оролцох хэрэгтэй байгаа юм. Бельги улсад очоод харахаар хүний харилцаа хандлагыг маш сайн хардаг юм билээ. Төр, засаг судалгааны байгууллага, хувийн хэвшил хамтарч чаддаг гэдгээ гаднынханд харуулаад итгэлийг нь олоод явбал “Найрамдал” шиг ийм хэрэгтэй төсөл Монголд байхгүй.

–Танай “Ихр дөл” төсөл Европын төслийн санхүүжилтээр үйлдвэрлэл явуулах цех барих хөрөнгө оруулалтын гэрээ хийгээд, хөрөнгө оруулалтаа хүлээж байгаа гэсэн. Танай цаашдын төлөвлөгөө юу байгаа вэ?

–“Найрамдал” төслөөр дамжуулаад “Green work concalting” компани манайд тусгайд нь зориулж хөрөнгө оруулалтын төсөл хийж өгсөн. Камлеш Кумар Патак зөвлөх сайн бүтээгдэхүүн байна гэж үнэлж старт апп болгож хөгжүүлэхээр тусгайлан төсөл бичиж өөрөө хөрөнгө оруулалтыг нь босгож өгсөн. Хэдий хир санхүүжилт орж ирэхийг мэдэхгүй. Миний өөрийн гаргасан тооцоолол бол 736 сая төгрөг байгаа.

Харин аймгийн зүгээс манай үйлдвэрлэлийг дэмжиж, 1130 ам.метр үйлдвэрлэлийн зориулалттай газар өгсөн. Хөрөнгө оруулалт ороод ирвэл 35-аас дээш насны хүмүүсийг ажлын байраар хангаж, ажиллахаар төлөвлөж байна. Одоогоор өөрийн бололцоогоор сард 20 зуух л хийж байна. Цаашид энэ нь хоёр дахин өсөх боломжтой. ■



“Science” кафе

Кофе уунгаа шинжлэх ухааны туршилт хийгээрэй



“Найрамдал” төслийн дэргэдэх Европ-Дарханы Инновац Энтрепренершип төвийн бойжигч “Сапиожен” ХХК нь “Гарааны бизнесийн төслийн уралдаан”-ын DEMO DAY өдөрлөгт Шинжлэх ухааны мэдлэг боловсрол чиглэлд амжилттай оролцон шилдэг гарааны бизнесүүдийн нэгээр шалгаран 20000 хүртэлх еврогийн санхүүгийн болон техникийн дэмжлэг аван гэрээ хийснээр албан ёсоор тус төвийн бойжигч хэмээн нэрлэгдэх болжээ. Уг төслийн зорилго нь зөвхөн кофе шопоор үйлчлээд зогсохгүй төрөл бүрийн шинжлэх ухаанд чиглэсэн арга хэмжээ, эвентүүдийг тогтмол зохион байгуулж, хүүхэд залуучуудыг шинжлэх ухаанд дурлуулах, дуртай болгох юм.

Тодруулбал, “Science” кафе хөдөлгөөний хүрээнд олон улсын жишгийн дагуу эрдэмтэд, судлаачид, инженерүүд болон бусад мэргэжилтнүүдэд мэдлэгээ тогтмол цуглуулж, хуваалцах тусгайлсан газар, платформыг бий болгох замаар Монгол Улсын шинжлэх ухааны суурь болон албан бус боловсрол,

мэдлэгийг дээшлүүлэх зорилготой аж. Мөн оюутан, сурагчдад аливаа зүйлийг гараар хийж бүтээх, туршилт хийж сурахыг хүссэн хүмүүст хүртээмжтэй, хамтын сургалтын орон зайгаар дамжуулан шинэ зүйл сурч, дадлага хийх орчныг бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

“Science” кафе төслийн шууд үр шим хүртэгчид нь мэдлэг чадвараа хуваалцах боломжтой эрдэмтэн инженерүүд, шинжлэх ухааны сонирхолтой сэдвүүдийг тав тухтай орчинд сурах боломжтой оюутан залуучууд, хүүхэд болон насанд хүрсэн хүмүүс байх аж. Харин шууд бус үр шим хүртэгчид нь олон нийт, нийгэм, эдийн засгийн хүрээнд үр шим хүртэх залуус байх нь ээ. Уг төсөл нь хүүхдүүдэд судлаач, эрдэмтэн, инженерүүдийн ажлын байр ямар байдгийг бодитойгоор мэдрүүлэх, хими, физик, биологийн салбарын үйлдвэр, компани, судалгааны төв, лаборатори зэрэг газраар экскурс хийх Bridging program-р дамжуулах байгалийн ухааны мэргэжлийг сурталчлан ажиллаж байгаа юм байна. ■



“Өөрчлөлтийг хамтдаа авчиръя”

700 гаруй сая төгрөгийн 6 зорилтот төсөл хэрэгжүүлэв

“Найрамдал” төслийн хүрээнд Дарханд мэдээллийн технологийн дэвшлийг шингээсэн төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, хотын дэд бүтэц дээр тулгамддаг асуудлуудаас ногоон хөгжил мэдээлэл технологийн болон “ноу хау” шингээсэн төслүүдийг хэрэгжүүлжээ. Тодруулбал, хотын дэд бүтэц, нийгмийн дэд бүтцийн гурав, гурван туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Нийт 700 гаруй сая төгрөгийн

зургаан зорилтот төсөл хэрэгжүүлсэн бөгөөд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах “Жишиг хороолол” төсөл, ухаалаг худгийн төсөл, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, “Home Center” СӨХ-ийн менежментийг сайжруулах төсөл, “Виртуал Шинжлэх Ухааны музей” төсөл, Дархан-Уул аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө боловсруулах D-CAMP төслүүдийг дурдаж болно.

“Дархан-Уул аймгийн Дархан сумын 5, 8 дугаар багийн гэр хорооллын айл өрхийн инженерийн шугамын чиглэлийн болон хэрэглэгчийг холбох зураг төслийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэх” төсөл

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багийн Хүнсний арын хэсэг, 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгойн айл өрхийг гадна инженерийн шугамд холбох 591 айлын зураг төсөл хийж гүйцэтгэжээ. Иргэдийн хөрөнгө мөнгөний боломжгүй байдлаас болон мэргэжлийн байгууллагын тооцоолол, судалгаагүй үйл ажиллагаанаас шалтгаалан гүйцэтгэх боломжгүй байсан ажилд ийнхүү хөрөнгө оруулсан нь үр дүнгээ өгсөн байна.

Зураг төслийн үр дүнд гэр хорооллын одоо байгаа түвшинг ахиулж зураг төсөл хийсэн 3 байршил болох 5 дугаар баг Хүнсний ар, 8 дугаар баг Нарантолгой, Манхантолгой байршил дээр дулааны шугам сүлжээг татах боломжтой болсон байна. Ингэснээр айл өрхийн амины орон сууцны тогтолцоог сайжруулж, дулаан алдагдалгүй болгож, өргөтгөх эсвэл шинээр сууц барихад иргэдэд техник, санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм. Эдгээр гурван байршлын онцлог нь 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгой нь Дархан хотын төв хэсэгт байрладаг. 5 дугаар багийн Хүнсний арын хэсэг салхины толгой хэсэгт байрладаг бөгөөд салхи их салхилж ойр орчныхоо агаарыг бохирдуулах хандлагатай байдаг байна.



Байгаль орчинд үзүүлэх нөлөө талаасаа эдгээр айл өрх дэд бүтцэд холбогдсоноор гэр хорооллын яндангийн тоо буурч үүнийгээ дагаад яндангаас ялгарах хүлэмжийн хий болон нүүрсхүчлийн хий багасаж, Дархан хотын агаарын бохирдлыг бууруулах боломжтой. Нүхэн жорлонг халж төвийн бохирын шугамд холбогдсоноор нүхэн жорлонгоос шалтгаалсан хөрсний бохирдол багасаж, хөрсний бохирдлоос үүсдэг олон төрлийн халдварт өвчлөлийн тоо буурах юм.

“Жишиг хороолол” төсөл

Энэхүү нийгмийн энтерпрайз төсөл нь Дархан-Уул аймгийн 2022-2032 он хүртэлх хог хаягдлын мастер төлөвлөгөөний хурдасгуур болж байгаа төсөл юм. Орон сууцны хорооллын айл өрхөөс гарах хог хаягдлын суурь судалгааг хийж аймгийн удирдлагуудад бодлогын зөвлөмж боловсруулах



зорилготойгоос гадна зорилтот орон сууцны хорооллын 260 айлын хог хаягдал түр хадгалах савыг дэвшилтэт шийдэл бүхий ангилан ялгах байгууламжаар солих, ангилсан хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой. Төсөл хэрэгжих энэ хугацаанд төслийн шууд болон дам үр шимийг хүртэгчид, бүх шатны боловсролын байгууллагууд, иргэдэд хог хаягдлын талаарх мэдлэг олгох сургагч багш нар, сайн дурын ажилтнуудыг бэлтгэх, сайн дурын ажилтны менежментийг сайжруулахад ТББ-ын ажилтнуудыг чадавхжуулах зэрэг сургалт нөлөөллийн ажлуудыг шат дараатайгаар зохион байгуулсны үр дүнд орон нутагт цаасны хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, Варианы шил дахин ашиглах цех үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа нь хамгийн том үр дүн юм.



“Ус түгээх цэгүүдэд цахим төхөөрөмж суурилуулах” төсөл

“Ус түгээх цэгүүдэд цахим төхөөрөмж суурилуулах” төслийг хэрэгжүүлснээр Дархан хотын гэр хорооллын иргэдийн ус хангамжийн болон үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлэх ач холбогдолтой.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1,3,5,6,7,8-р багийн 42 ус түгээх байруудад ухаалаг төхөөрөмж



бүхий 24 цагийн үйл ажиллагаанд шилжүүлсний үр дүнд иргэд хамгийн чухал хэрэгцээ болсон ундны усаа илүү хүртээмжтэй, илүү хяналттай, аюулгүйгээр хүртэх боломж бүрдэж байгаа юм.

“Home center” төсөл

“Home center” төслийн зорилго нь ERP системийн суурьтай СӨХ-ны цахим апп хөгжүүлэх замаар СӨХ-ны үйл ажиллагааг чанаржуулах, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн цахим апп-ыг нэвтрүүлэх замаар иргэдийн хянах, оролцох, дуу хоолойгоо хүргэх эрхийг хангана. Оршин суугчдын СӨХ-тэй холбоотой төлбөр, тооцоо, санал хүсэлт, үйл ажиллагаанд хяналт тавих, хамтран ажиллах зэрэг олон талын эерэг үр дүн гаргах зорилготой төсөл юм.

“Home center” төв нь байгуулагдсанаар иргэд илүү хялбар аргаар төлбөрийн нэгдсэн системээр төлбөр тооцоогоо төлөх, СӨХ-ийн үйл ажиллагааг цахимаар буюу гар утасны апплейкшнээр дамжуулан хянах, амьдрах орчноо илүү таатай болгож, үнэ цэнийг нь өсгөх боломж бүрдэх юм.

“Виртуал Шинжлэх Ухааны музей”

Дархан-Уул аймагт Шинжлэх ухааны музей нь VR технологид суурилсан бүх насныхны танин мэдэхүйн болон шинжлэх ухааны мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хүүхэд залуучуудын дур сонирхлыг шинжлэх ухааны бүтээл туурвилуудад татах, бүтээлч болон шинжлэх ухаанч сэтгэхүйг дэмжин хөгжүүлэх зорилготой нийгмийн энтерпрайз төсөл юм. Төслийн хугацаанд Дархан-Уул аймгийн ХААИС-ийн Агро экологийн бизнесийн

сургуулийн Козен хөтөлбөрийн оюутнуудад зориулан хиймэл оюуны талаар суурь мэдлэг олгох, шинэ технологиудыг бодит хэрэглээнд нэвтрүүлэх ур чадварыг хөгжүүлэх, график болон код суурьтай хэрэгслүүдээр бүтээгдэхүүн бүтээх болон IT төслийн менежмент, AI хөгжүүлэлтийн чиглэлээр дадлагажуулах зорилготой сургалтыг амжилттай зохион байгуулсан билээ. Мөн Дархан-Уул аймгийн ЕБС-ийн 30,31, 9-р сургуулийн сурагчдад болон Дархан политехник коллежийн оюутнуудад виртуал шинжлэх ухааны музейн 23 контентыг таниулах зорилготойгоор үнэ төлбөргүйгээр үзүүлж сэтгэл ханамжийн судалгааг авсан.



“Дархан нүүрсхүчлийн хийн зах зээлийн хөтөлбөр (D-CAMP)”

Солонгосын “Бифлаг сервисэс”, “Трийнвөркс” консалтинг компаниуд Ус, хог хаягдал, эрчим хүчний чиглэлийн (нийгмийн дэд бүтцийг бий болгох) зорилтот төслийн 2024 оны шалгаруулалтад амжилттай оролцон шилдэг төслөөр шалгаран 100 сая хүртэлх төгрөгийн санхүүгийн болон техникийн дэмжлэг авах гэрээ үзэглэв. Уг төслийн зорилго нь Хог хаягдал, ойжуулалт, боломжийн өртөгтэй эко орон сууц гэх мэт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сайн дурын нүүрсхүчлийн хийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах чадавхыг бэхжүүлэх, бүсийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах зорилготой юм.

№	Найрамдал төслийн хүрээнд боловсруулагдсан баримт бичгийн жагсаалт
1.	Curriculum for public officials' capacity building 2024
2.	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр 2024
3.	Ухаалаг Дархан хотын жишиг загварыг боловсруулах нь судалгааны тайлан
4.	Darkhan smart city development concept
5.	Ухаалаг Дархан хотын хөгжлийн концепц
6.	Incubation and acceleration
7.	Инкубатор ба хурдасгуур
8.	Ухаалаг Дархан-Уул аймгийн дижитал шийдэл бүхий бүтээгдэхүүнүүд тэдгээрийн уялдаа холбоог хангах эко системийн ажлын даалгавар
9.	Дээд боловсролын салбар дахь дижитал шилжилтийн төлөвшлийн загвар
10.	Maturity model for digital transformation in higher education
11.	Дээд боловсролын салбар дахь дижитал шилжилтийн тогтолцоо
12.	Framework for digital transformation in higher education
13.	Decentralized cooperation handbook
14.	Төвлөрлийг сааруулах хамтын ажиллагааны гарын авлага
15.	Mentorship program
16.	Менторинг хөтөлбөр гарын авлага
17.	Development of smart Barkhan city activities conceptual reference model